## ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН 2016 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2016 оны 12-р сарын 20-ны өдөр Мандалговь

2016 онд байгууллагын бүтэц өөрчлөлтөд орж 2016 оны 1 сарын 1-нээс 7 сарын 21 хүртэл Улсын бүртгэл, статистикийн газар болж өргөжин ажилласан. 2016 оны 7 сарын 21-нээс Үндэсний Статистикийн хороо шинэчлэгдэн байгуулагдсанаар Статистикийн хэлтэс бие даан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Тус хэлтэс нь дарга, үндсэн мэргэжилтэн 4, гэрээт ажилтан 2, судлаач 2, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж дараах ажил үүргийг гүйцэтгэлээ.

МУ-ын Статистикийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг удирдлага болгон, УБСЕГ-ын дарга, аймгийн Засаг дарга, УБСГ-ын газрын дарга нарын хооронд байгуулсан үр дүнгийн гэрээ, удирдлагуудаас өгсөн ажлын чиглэл, тогтоол шийдвэрүүдийг үндэслэн албан ёсны статистикийн мэдээллийн хамрах хүрээг нэмэгдүүлэх, үнэн зөв, шуурхай бодит байдлыг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглалтыг сайжруулах, судалгааны чанарыг сайжруулах, мэргэжилтнүүдийн ажлын хариуцлагыг дээшлүүлэн идэвхи санаачлага, бүтээлч ажиллагааг эрчимжүүлэх, аймгийн хөдөө аж ахуйн байдал, хүн амын чиглэлээр танилцуулга бэлдэх, хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн сангийн хөтлөлтийг сайжруулах, мэдээллийн технологи портал вэб сайтын баяжилтыг хангах, хэрэглэгчдэд үйлчлэх зорилтуудыг өмнөө тавьж амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа.

## I БҮЛЭГ: АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАМРАЛТ, ДАМЖУУЛАЛТ

### 1.МЭДЭЭНИЙ ХАМРАЛТ (Ш1)

Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны 12 сарын 30-ний А/159 тоот тушаалаар батлагдсан 2016 оны албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн нэгдсэн графикийг мөрдөж, оны эхэнд ирсэн хүрээгээр аж ахуйн нэгжүүдийг бүрэн хамруулж, нийт 15 сумын давхардсан тоогоор 280 гаруй аж ахуй нэгжийг хамруулах ёстойгоос 280 аж ахуй нэгжийг хамруулж мэдээ тайлан, судалгааг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан. Үүнээс мал эмнэлэгийн 22, тээвэр 2, холбооны 3, аж үйлдвэрийн 14, зочид буудлын 9, зоогийн газрын 15, төрийн бус байгууллагын 11, сүм хийдийн 8, аялал жуулчлалын 9, барьцаалан зээлдүүлэхийн 15, худалдааны 29, нийгэм бие хүний мэдээ 1, мэргэжлийн түр сургалтын 3, сонин сэтгүүлийн 1, хөрөнгө оруулалтын 5, барилгын 19, жилийн эцсийн аж ахуйн нэгжийн мэдээгээр 114 газраас мэдээг авч бүрэн хамруулсан байна.

Мэдээний хүрээнд зайлшгүй өөрчлөлт орох тохиолдолд холбогдох газар, хэлтсийн мэргэжилтэнтэй тохирч байгаа учир мэдээний хамралт 100 хувьтай байгаа юм. 2016 оны жилийн эцсийн байдлаар мэдээний тасалдал, хожимдол гаргаагүй, мэдээний графикт өдрийн 17 цагт багтаан мэдээг бүрэн оруулж нэг бүрчлэн шалгаж,

мэдээ мэдээллийн чанарын асуудалд анхаарлаа хандуулан, хамралт бүрэн байгаа эсэхийг үзэж, холболтыг хийж дамжуулдаг.

## 2. МЭДЭЭНИЙ ДАМЖУУЛАЛТ (Ш2)

Энэ оны жилийн эцсийн байдлаар ҮСХ-д мэдээг 100 хувь хугацаанд нь гаргаж, дамжуулбал зохих графикт өдөр нь бүрэн дамжуулсан. Тухайн жилд мэдээ дамжуулах, холболт хийхэд ямар нэг саатал гараагүй үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Сар бүрийн 1, 4, 5, 8, 21, нд нийт сард 5 удаа мэдээ дамжуулж байна. Мөн 7 хоног бүрийн 3 дахь өдөр үнийн мэдээг аймгийн төвийн зах, дэлгүүрүүдээс авч тогтмол дамжуулж хэвшсэн.

Мэдээнүүдийг програмын дагуу шивж, алдааг бүрэн засварлан үр дүнгийн хүснэгтийг үүсгэн өнгөрсөн мөн үе болон өмнөх сарын мэдээтэй уялдуулан шалгаж, тодруулах шаардлагатай мэдээг ААНэгжүүдээсээ тодруулан шалгадаг.

Нийт 68 нэрийн давхардсан тоогоор 1358 мэдээг 100 хувь хугацаанд нь бүрэн интернетээр дамжуулсан. Үүнд хөдөө аж ахуйн ХАА-1, ХАА-2, ХАА-3, ХАА-6, ХАА-7, ХАА-8, ХАА-9 мэдээнүүдийг 15 сумаас нийт 480 мэдээг, аж үйлдвэрийн мэдээг сар бүр 10 ААН-с нийт 120 мэдээ, тээврийн 2, зочид буудал, зоогийн газрын 92, худалдааны 116, төрийн бус байгууллагын 36, мал эмнэлгийн 108, сүм хийдийн 32, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний 60, мэргэжлийн түр сургалтын 12, холбооны 12, орон сууц нийтийн аж ахуйн 4, бизнес регистрийн 41 аж ахуйн нэгжийн мэдээллийг, хүн амын ХА-3 мэдээг 66 багаас жилд 1 удаа, НЗҮ-1а мэдээг 15 сумаас 1 удаа ХА-2, Ха-1 мэдээг нэг удаа, ОС-1 мэдээгээр 59, барилгын 76, хөрөнгө оруулалтын 20, хэрэглээний үнийн 12 мэдээг тус тус тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээллээ. Графикт мэдээнээс гадна үйлдвэрлэгчийн үнийн судалгаанд сонгогдсон зоогийн газрын 3, зочид буудлын 1 газрын мэдээг улирал бүр, худалдааны 10 газраас үнийн мэдээг сар бүр авч ҮСХ-д дамжуулан ажиллаа. Харин сонгогдсон аж ахуйн нэгж тухайн сар, улиралд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулаагүй тохиолдолд мэдээ бүрийн тайлбарыг хамт явуулж байлаа.

## 3. МЭДЭЭНИЙ БОДИТ БАЙДАЛ, ЧАНАР (Ш3)

ҮСХ-нд дамжуулах мэдээ тайланг салбар хариуцсан мэргэжилтнүүд сумд болон мэдээлэгчдээс шалган авч програмд боловсруулсны дараа хэлтсийн ахлах мэргэжилтэн хүлээн авч логик шалгалтуудыг хийж өнгөрсөн оны болон өмнөх сарын гүйцэтгэлүүдтэй зэрэгцүүлэн үзэж баталгаажуулан төвд мэдээлж байснаар мэдээ тайлангийн алдаагүй ажиллаж байна.

Ì ýäýýã õóãàöààí ä í ü шивэхээс ãààí à ì ýäýýí èé ÷àí àðò àí õààð÷, ì ýäýýã ¿í ýí çº â ýñýõýä áàéí ãû í õÿí àëò òààâüæ, сангийн яам, татварын хэлтэст өгсөн мэдээтэй тулган үзэж байна.

Мөн сумдын ажилтнуудад мэдээний анхан шатны бүртгэлийг шалгаж тухай бүр заавар зөвлөгөө өгч ажилласан. 2016 оны байдлаар ихэнх сум интернетэд холбогдож, шууд харилцаж байна. Шаардлагатай яаралтай мэдээллийг байгууллагын вэб сайт болон газрын хаалттай face group-ээр дамжуулан түргэн хугацаанд сумдтай холбогдон авч байна. Жилийн эцсийн байдлаар мэдээний ямар нэгэн алдаа гаргаагүй байна.

## 4. ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (Ш4)

2016 он гарсаар ХАӨМСанд регистрийн дугаарын давхардалтай хүн, мэдээллийн санд ороогүй хүүхэд, хүчингүй регистрээр бүртгэгдсэн зэрэг нийт 2000 гаруй хүний мэдээллийг иргэний бүртгэлийн ахлах бүртгэгч Б.Сайхантуяатай хамтран тулгаж тухай бүр тодруулан мэдээллийн санг баяжуулан ажиллаж байна. Завсрын тооллогын үр дүнгээр гарсан хүн ам өрхийн мэдээллийг тооллогын товчооноос файлаар хүлээн авч, шаардлагатай газруудад хүргүүллээ. Тооллогын товчооноос 14 хоног тутамд уншигдан ирж байгаа ХАӨМСангийн алдааг сум бүрт тухай бүр хүргүүлэн алдааг засварлан ажиллаж байна. Мэдээллийн сангийн баяжилт баталгаажуулалтыг сумдууд тогтмол хийж байна.

Жилийн эцсийн ХА-3 болон НЗҮ-1а мэдээг ХАӨМСантай тулгаж авахаар төлөвлөн сумдад албан чиглэл хүргүүлээд ажиллаж байна. Зарим аймаг, нийслэл шилжин очиж байгаа иргэдээ тухай бүр мэдээллийн сандаа оруулж авахгүй байгаагаас шалтгаалан ХАӨМСангийн хүн амын тоо ХА-3 мэдээнээс илүү харагдах тохиолдол гарч байна. 2016 онд УИХ, орон нутгийн сонгууль болсонтой холбогдуулан ХАӨМСангийн түүвэр татах жагсаалт харуулах хэсэг 5-11 сард ажиллахгүй байсан учир өнгөрсөн онтой харьцуулахад БЗД нарын хандалт бага зэрэг буурсан хандлагатай байна.




2016 онд нийтдээ төрийн сангийн мэргэжилтний 3, багийн Засаг даргын 7 нотебүүкд ХАӨМСангийн программыг суулгаж заавар зөвөлгөө, чиглэлийг утас мэйлээр тогтмол өгч ажилласан. Мэдээллийн сангийн баяжилтыг хянах ажлыг хэлтсийн бусад ажилтай хамтран Эрдэнэдалай, Дэлгэрхангай, Хулд, Луус, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн, Говь-Угтаал сумдад ажилласан. Хяналтаар ажиллах явцад БЗД нараас программын захидал хэсгийг илүү боловсронгуй болгож чат хэлбэрт оруулан бусад аймаг, сумдтай хурдан харьцах боломжийг нэмэгдүүлэх санал ихээхэн гарч байсан. Хэлтсээс зохион байгуулж буй сургалт, сурталчилгааны ажлуудад тухайн програмыг танилцуулан ажиллаж байна.

### 5. БИЗНЕС РЕГИСТРИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (Ш5)

2016 оны байдлаар бизнес регистрийн санд бүртгэлтэй 861 аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд байна. Үүнийг үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар авч үзвэл үйл ажиллагаа явуулж байгаа 585, үйл ажиллагаа нь эхлээгүй 95, үйл ажиллагаагаа түр зогсоосон 156 үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон 23, бусад шалтгаантай 2 байгууллага байна.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй  аж ахуйн нэгжийн 67,9 хувь буюу 585 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулдаггүй, эзэн нь өөр аймаг хотод шилжсэн, бүртгэлээс хасах боломжтой нилээд аж ахуйн нэгжүүд байна.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй 861 байгууллагыг хариуцлагын хэлбэрээр нь авч үзэхэд ХХК - 475, ХК - 4, ББН - 8, ЗБН - 2,  хоршоо - 103,  ТӨҮГ - 1, ОНӨҮГ-19, төсөвт байгууллага-137, ТББ-112 байна. Өмчийн хэлбэрээр нь авч үзэхэд 2015 онд төрийн 108, хувийн 699, гадаад улсын 2, орон нутгийн өмчийн 52 нийт 861 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байна.

Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг сумдаар нь авч үзвэл Сайнцагаан суманд 290 буюу 49,6 хувь, Эрдэнэдалай суманд 37 буюу 6,3 хувь нь ногдож байна. Цагаандэлгэр, Дэрэн, Говь-Угтаал, Луус суманд хамгийн бага буюу 14-16 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Жилийн эцсийн болон энэ онд  сонгогдон ирсэн шинээр бүртгүүлсэн 49 аж ахуйн нэгжээс БР-1 маягтаар аж ахуйн үйл ажиллагааны тухай мэдээллийг тодруулан авч шинэ програмд оруулан  мэдээллийг шинэчилж байв.

Монгол Улсын “Статистикийн тухай хууль”-д аж ахуйн нэгжийн тооллогыг 5 жилд нэг удаа явуулж байхаар заасны улмаас Засгийн газраас шийдвэрлэсний дагуу УБСЕГ-аас уг тооллогыг 2016 оны 4 дүгээр сард  явуулахаар аймгийн хэмжээнд нийт хүрээгээр ирсэн 826 газраас татан буугдсан 38, бусад шалтгаантай 2 газраас бусад 786 газар бүрэн тоологдсон. Нэмэлт хүрээгээр ирсэн ААНБ-уудаас шинээр нэмж 35 ААНБ, 66 салбарыг тооллогод хамруулж, нийт 887 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсан ба шалтгаантай 40 газрын шалтгааныг тодруулж програмд оруулж, мөн нэмэлт хүрээгээр ирсэн байгууллагуудын шалтгааныг тодруулж, тайлбарыг УБСЕГ-н ТСМГ-ын ахлах мэргэжилтэнд хүргүүлсэн болно.

## <u>II БҮЛЭГ. ТООЛЛОГО, СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН</u>

### 6. МАЛ ТООЛЛОГО (Ш6)

<u>А.Хагас бүтэн жилийн мал тооллогын бэлтгэл ажил, зохион байгуулалт</u>

А.1 Хагас, бүтэн жилийн мал тооллогын бэлтгэл ажил: Монгол Улсын “Статистикийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйл 1 дүгээр хэсгийн в, л дэх заалтын дагуу хагас жилийн малын түүвэр судалгааг 6 дугаар сарын 15-22-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд нийт 15 сумын 1253 өрх, 6 ААНБ сонгогдож судалгаа авахаас 1253 өрх, 6 ААНБ-аас судалгаа авлаа.

Хяналтаар ажиллахдаа УБСГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу тухайн сумдын баг бүрээс айлыг сонгож түүвэр судалгаанд сонгогдсон нийт өрхийн 10 хувьд хяналт хийхийг зорилго болгосон.

Хагас жилийн мал тооллогоор түүвэрлэгдсэн өрхийн жагсаалтаас өөрсдийн хяналтаар явах маршрутыг гаргаж маршрутын дагуу дараахь байдлаар ажиллав.

| д/д | Сумдын нэр | Сонгогдсон өрхийн тоо | Хяналт хийсэн өрхийн тоо |
|---|---|---|---|
| 1 | Дэлгэрхангай | 79 | 13 |
| 2 | Хулд | 89 | 10 |
| 3 | Луус | 60 | 12 |
| 4 | Өлзийт | 103 | 18 |
| 5 | Гурвансайхан | 76 | 13 |
| 6 | Адаацаг | 95 | 12 |
| 7 | Дэрэн | 76 | 11 |
| 8 | Дэлгэрцогт | 64 | 9 |
| | Нийт | 642 | 98 |

Сумдад багийн дарга нар болон төрийн сангийн мэргэжилтэн, ХАА-н мэргэжилтнүүдтэй хамтран хяналт хийлээ. Хяналтын явцад дээрх өрхүүдээр орж судалгааны асуулгаар мэдээлэл авч багийн даргын шивэлттэй тулгалаа.





Сумдын тооллогын хэсгүүд нэлээд нь тооллогоо явуулж дууссан, айл өрхүүдийн материалыг шивж дууссан байв. Зарим хэсэг нь газар нутаг хол айл сонгогдсоноос шалтгаалан хараахан сумын төвд орж ирж амжаагүй байлаа. Малчидтай уулзаж ярилцахад багийн дарга нар хагас жилийн мал тоолохоор ирж, зарим айлын малыг нүд үзэж тоолсон, зарим айлын малыг ам тоо авсан байлаа.

Бид зарим айлуудын бог малыг бэлчээр дээр болон усан дээр нь тоолж, зарим бод малыг /гаднаа байгаа ботго, унага, адуу зэргийг/ нүд үзэж тоолсон. Тоолсон малын тоог багийн дарга нарын тоотой тулгаж шалгасан, зөрүү гараагүй. Мал тооллогыг маягтуудыг шалгаж үзэхэд хагас жилийн мал тооллогын маягтуудыг маш сайн, хариуцлагатай нөхсөн байсан.

 

Жилийн эцсийн мал тооллогын сургалтыг статистик мэдээ хариуцсан ажилтнууд буюу төрийн сангийн мэргэжилтнүүд, сумдын Засаг дарга нар, ИТХ-ын дарга нарт зориулсан сургалтыг 2016 оны 12 сарын 01-ны өдөр Дундговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн 3-р хуралдааны үеэр амжилттай зохион байгууллаа. Сургалтанд сумдын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга, Сайнцагаан сумын багийн Засаг дарга, түүний туслах ажилтан нар, сумдын төрийн сангийн зарим мэргэжилтэн, санхүү албаны дарга нар оролцлоо.



Сургалтаар статистикийн салбарын эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, жилийн эцсийн мал тооллогын зохион байгуулалт, анхаарах асуудал сэдвүүдээр сургалт хийлээ.

Тооллого явуулах ажлын хэсгийн даргын баталсан удирдамж, сумдад хяналт хийх бүрэлдэхүүн чиглэлийн дагуу 2016 оны 12 сарын 12-аас 17-ны өдрүүдэд аймгийн нийт 8 суманд 4 хэсэг гарч 2016 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын явцад хяналт хийлээ. Хяналтын тооллогын зардлын тооцоог 2,424.6 мянган төгрөгөөр төсөвлөн Засаг даргаар батлуулж Засаг даргын нөөцөөс зарцуулсан болно.

- Дэлгэрхангай, Хулд сумдад ХААГазрын дарга Б.Мөнхжаргалаар ахлуулж ХОХБТХэлстийн мэргэжилтэн А.Өлзийбалжир, Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Уянга, Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Г.Ариунжаргал нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг,

- Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдад тус хэлтсийн дарга Б. Энхтуяа, НДХ-ийн дарга Ч. Баяраа, ХШҮДАХ-ийн дарга Г.Самданцоодол, судлаач Ж. Мөнхбаяр, жолооч А.Өлзийдүүрэн нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг,
- Баянжаргалан, Гурвансайхан сумдад Онцгой байдлын газрын дарга Я.Алтанхундагаар ахлуулсан хэлтсийн мэргэжилтэн Н.Түвшинжаргал, Г.Баясгалан нар хамтран ажиллаа.
- Дэлгэрцогт, Адаацаг сумдад Аймгийн ЗДО Ж.Мөнхчулуун ахлагчтай Цагдаагийн хэлтсийн Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн дарга хошууч Н.Дэлгэрсайхан, Дэлгэрцогт сумын ИТХ-ын дарга П.Цолмонбаатар, Статистикийн хэлтсийн мэргэжилтэн С.Доржханд, АЗДТГ-ын жолооч Ц.Доржбалдан нар ажилласан.

Дээрх ажлын хэсгүүд нь хяналтын тооноос гадна өвөлжилтийн байдал, отор нүүдлийн байдалтай танилцах зорилготой ажилласан.







Томилолтын хугацаанд сумдуудын мал тооллогын ажлын хэсэг тооллогоо дуусгаад ирсэн байсан тул сумдын Засаг дарга, төрийн сангийн мэргэжилтэн, багийн дарга нар, хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтнүүдтэй уулзаж удирдамж, чиглэлээ танилцуулж, хяналт хийх өрхийн маршрут чиглэлээ гаргалаа. Мөн тухайн сумын мал тооллогын захирамж гарсан эсэх, тооллогын зохион байгуулалт, ажлын төлөвлөгөөтэй танилцан зохих заавар зөвлөмж өгч ажиллаа.

Сумдад Сумын засаг даргын захирамжийн дагуу сумын засаг даргаар ахлуулсан комисс томилогдож, 2015.12.07-2015.12.17 хугацаанд нийт 52 хэсэгт 140-д хүн ажиллаж, амжилттай зохион байгуулагдаж байна. Сум бүрт мал тооллого явуулах сургалтыг 2016.12.07–ны өдрөөс өмнө мал тооллогын комисс болон мал тооллогод ажиллах хүмүүсийг хамруулан нэгдсэн семинар хийж, тооллогын ажлыг хугацаанд нь холбогдох хууль, журмын дагуу чанартай зохион байгуулж, ажлын сахилга батыг өндөржүүлж ажиллахыг нийт дарга гишүүдэд үүрэг болгож, заавар өгч гаргасан байлаа. Мөн сумдын тооллогын үйл ажиллагаанд зарцуулах зардлыг батлуулан сум орон нутгийн төсвөөс гарган зарцуулсан байна. Жишээ нь: Дэлгэрхангай суманд 671,7 мянган төгрөг, Хулд суманд 618,3 мянган төгрөг гэх мэт зарцуулсан байна.

Дээрх сумдын хувьд Сайнцагаан, Дэлгэрцогт, Адаацаг зэрэг сумдаас отроор нилээн олон өрх нэг сумын нутагт ирж оторлосон тохиолдолд байгаа нь тухайн сумын бэлчээрийн даац болон худаг усны асуудал ихээхэн тулгамдсан асуудал болоод байна. Тухайн сумын өрхүүдээс гадна тус суманд отроор явж байгаа өрхүүдээр орж мал

тооллогын хяналтаас гадна өвөржилт болон тэдэнд тулгарч буй хүндрэл бэрхшээл зэрэг асуудлаар ярилцаж аймаг, сумын удирдлагуудад дамжуулж өгөхөөр ярилцлаа.





Малчид отроор бусад сумын нутагт дур мэдэн малаа аваачин өвөлжиж байгаа нь энэ жилийн хувьд аймгийн хэмжээнд малын халдварт өвчин нэлээд гарч байгаа асуудлыг хүндрүүлэх эрсдэлтэй байна. Энэ асуудлыг аймгийн ХААГазрын дарга удирдлагын түвшинд хэлэлцэж шийдэхээр боллоо.





Сумдын хяналтаар явсан өрхүүдийн малын тоог сумдын тооллогын дүн мэдээ болон МТ-1 маягттай тулган шалгаж үзэхэд ямар нэг ноцтой зөрчил гарсангүй. Хяналтын тооллогын үр дүнг тухайн сумын мал тооллогын комиссд танилцуулж малын тооллогыг үр дүнтэй зохион байгуулах, багийн дарга нар цаг хугацаанд нь программд шивж оруулах, малын урьдчилсан тоо мэдээ болон эцсийн тоо мэдээг цаг хугацаанд нь гаргах талаар заавар зөвлөмж өгч, зарим асуудлыг газар дээр нь шийдэх талаар анхааруулж ажиллаа.

Мөн зөвхөн хяналтын тооллогын комиссоос гадна тус хэлтсийн судлаач нар Дэрэн, Говь-Угтаал сумдад ажиллахдаа мат тооллогын хяналтыг давхар хийсэн байна.

Доорх 10 суманд жилийн эцсийн мал тооллогын хяналт хийхэд Аймгийн нийт 6567 малчин  өрхийн 549 өрхөд хяналт хийсэн нь мал тооллогын хяналтын хамралт нь 8,4 хувьтай хийгдээд байна.




Дэлгэрцогт сумын Баянбулаг багт зарим өрхүүдэд мал тоолсон бичгийг үйлдэж орхиогүй зөрчил байсанг тооллогын комист анхааруулсан. Мал тооллогын шивэлтийн талаар 3 багийн Засаг дарга нарт заавар зөвөлгөө өгч, МТ-1 маягттай танилцаж, мөн Хүн ам, өрхийн мэдээллийн санийн шинэчлэлтийг үзлээ. Мөн хяналтын тооноос гадна Өвөлжилт, Отор нүүдлийн байдал, сум орон нутгийн тулгамдсан асуудлын талаар аймгийн ЗДО сумын удирдлагууд, холбогдох албаны хүмүүстэй уулзаж ярилцан заавар зөвөлгөө өгч ажиллаа. малчидаар баталгаажуулан гарын үсэг зуруулан, өрхөд мал тоолсон бичгийг үйлдэж үлдээн мал тооллогыг чанартай явуулсан байна.





Адаацаг сумын хувьд Төв аймгийн Алтанбулаг, Баян-Өнжүүл, Сэргэлэн, Баянцагаан , Бүрэн сумдын нутгаас оторчид их нүүдэллэн ирж байгаатай холбогдуулан Адаацаг сумын Хашаат, Эрдэнэдалай сумын Рашаант багийн нутгаар отроор ирсэн 10 өрхээр очиж өвөлжилтийн байдалтай танилцаж тухайн өрхүүд орон нутагтаа мал эмнэлгийн шинжилгээ вакцинд бүрэн хамрагдсан эсэхтэй танилцаж ажиллаа.

## 7.ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА (Ш7)

Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны судлаач нартай хэлтсийн даргын зүгээс шинээр гэрээ байгуулан, гэрээний дагуу үр дүнг тооцож ажиллаж байна.

Энэ оны байдлаар өрхийн нийгэм эдийн засгийн судалгаанд 624 өрх сонгогдож судалгаа авсан байна.

Судалгааг аргачлал зааврын дагуу явуулж, Үндэсний статистикийн хороонд графикт хугацаанд нь мэдээлж, Үндэсний статистикийн хорооноос ирсэн заавар аргачлалтай танилцаж, судлаач нарт танилцуулж, судалгааны чанар, хамралт, үнэн зөвд тавих шаардлагыг өндөржүүлэн хяналтыг сайжруулан судалгааны тоологчдыг өдөр тутмын заавар, зөвлөмжөөр ханган ажиллаж байна.

Судлаач нар судалгаанд хамрагдсан өрхүүдэд судалгааныхаа зорилго ач холбогдолыг танилцуулж, судалгааг тогтсон аргачлалын дагуу таблетаар, бүлэг тус бүрээр хэсэгчлэн авч, мэдээлэл цуглуулсныхаа дараа асуулгыг үзүүлэлт нэг бүрчлэн шалгаж нягтлан, хоорондын уялдаа холбоо, орлого зарлагыг тооцож, ажил мэргэжлээр кодолж, дамжуулах файл бэлтгэн ҮСХ-д графикт хугацаанд нь дамжуулж байна.

Дамжуулсны дараа сар бүр ахлагч судлаачын дамжуулсан өрхийг шалгаж алдааг уншуулан Үндэсний статистикийн хороонд хугацаанд нь дамжуулдаг.

Оны эхэнд өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг сумдад шалгах удирдамж, хяналт шалгалтын графикийг гарган энэ дагуу судалгааны ахлагч аймгийн төвд сар бүр 3-5 өрх, сумдад хэлтсийн ажлаар явж байхдаа зарим өрхөөр орж хяналт шалгалтыг тогтмол явуулж, өрхийн хүнсний хэрэглээ, өрхийн орлого зарлагыг бүрэн бүтэн асуусан байдал, урамшуулал нь эзэндээ очиж байгаа эсэхийг шалгаж байна. Мөн судалгаанд сонгогдсон өрхийн утасны жагсаалтыг тогтмол авч шаардлагатай үед холбоо барьж судалгааг баталгаажуулж байна.

## 8. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА (Ш8)

Ажиллах хүчний судалгааны хүрээгээр ирсэн багуудын өрхийн жагсаалтыг багийн засаг дарга нараас тухай бүр нь шинэчлэн авч Үндэсний статистикийн хороонд хүргүүлж байв.

Энэ жилийн байдлаар ажиллах хүчний судалгаанд 480 өрх сонгогдож судалгааг бүрэн авсан байна. Мөн ажиллах хүчний судалгаатай хамтатган хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, ногоон ажлын байрны судалгааг сонгогдсон айл бүрээс авч байлаа.

Судалгааг судлаач нар болон багийн ахлагч нар Үндэсний статистикийн хороонд графикт хугацаанд нь дамжуулж, судалгааны чанар, хамралт, үнэн зөвд тавих

шаардлагыг өндөржүүлэн хяналтыг сайжруулан судалгааны тоологчдыг өдөр тутмын заавар, зөвлөмжөөр ханган ажиллаж байна.

Ажиллах хүчний судалгааг сумдад шалгах удирдамж, хяналт шалгалтын графикийг гарган энэ дагуу судалгааны ахлагч аймгийн төвд сар бүр 2-3 өрх, сумдад хэлтсийн ажлаар явж байхдаа зарим өрхөөр орж хяналт шалгалтыг тогтмол явуулж байна. Ажиллах хүчний судалгааг шалгахдаа голлон тэр айлуудын ажил эрхлэлт бүрэн тусгагдсан эсэх, өрхийн ам бүлийн гишүүд бүрэн орсон байдал, нэмэлт хувиараа хөдөлмөр эрхлэлт, ногоон ажлын байрны мэдээлэл асуусан эсэх, өрхөөр орж урамшил эзэндээ тараагдсан зэргийг голлон үзэж танилцлаа. Мөн судалгаанд сонгогдсон өрхийн утасны жагсаалтыг тогтмол авч шаардлагатай үед холбоо барьж судалгааг баталгаажуулж байна.

## 9.ЭДИЙН ЗАСГИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА /Ш-9/

1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЗАРДЛЫН СУДАЛГАА

Цаг үеийн шаардлагаар УБСЕГ-аас нэмэлтээр Байгаль хамгаалах зардлын судалгааг 2016 оны 3 сарын 10-31-ны хооронд зохион байгуулсан юм. Дундговь аймгийн Байгаль орчныг хамгаалах зардлын судалгааны багт багийн ахлагчаар аймгийн УБСГ-ын Статистикийн хэлтсийн дарга Ж.Өлзийжаргал, судлаачаар Статистикийн хэлтсийн аж үйлдвэр худалдаа хариуцсан мэргэжилтэн Т.Бямбасүрэн ажиллаа.

Тус аймагт нийт 10 аж ахуй нэгж сонгогдон ирснээс 1 аж ахуй нэгж татан буугдсан байсан бөгөөд бусад аж ахуй нэгжүүдийг 100 хувь хамруулж судалгааг гаргуулан авсан юм. Судалгааг авахдаа аж ахуй нэгжүүддээ хүндрэл учруулахгүйн үүднээс аймгийн төвийн аж ахуй нэгжүүдэд судлаач биечлэн очиж авч ажилласан.

2. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН УЛСЫН ТООЛЛОГО

Монгол Улсын “Статистикийн тухай хууль”-д аж ахуйн нэгжийн тооллогыг 5 жилд нэг удаа явуулж байхаар заасан тул 2016 оны 4 дүгээр сард явуулахаар Засгийн газраас шийдвэрлэж, УБСЕГ уг тооллогын ажлыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

**Нэг.** Дундговь аймгийн УБСЕГ-ын Статистикийн хэлтсийн хамт олон 2016 оны 03 сарын 30-31-ны өдрүүдэд аж ахуй нэгж, байгууллагын улсын тооллогын тоологч, шалгагч нарыг бэлтгэх нэгдсэн сургалтыг амжилттай зохион байгуулж сургалтанд сумдын бүртгэл статистикийн ажилтан, төрийн сангийн мэргэжилтнүүдийг хамруулж нарийвчилсан заавар, чиглэлийг өгч ажилласан.

**Хоёр.** Аж ахуйн нэгж байгууллагын улсын тооллого зохион байгуулах аймгийн комисс аймгийн ЗДТГазрын даргын өрөөнд хуралдаж тооллогод зарцуулагдах шатахууны зардалд аймгийн Засаг даргын



нөөц сангаас 500000 төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэлээ. Мөн ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг гаргаж аймгийн хэмжээнд тооллогыг эрчимжүүлэх үүргийг бүх шатны байгууллагын дарга, нягтлан бодогч нарт өгч ажиллаа.

**Гурав**. Аймгийн төвийн төсвийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийн нягтлан бодогч нарт тооллогод нэн даруй хамрагдах хугацаатай үүрэг өгч үүний дагуу аймгийн төрийн сантай хамтран 4 сарын 6-ны өдөр нягтлан бодогчдод тооллогын болон статистикийн мэдээ мэдээллийг өгч сургалтанд хамруулснаар төсвийн байгууллагыг 2 хоногийн дотор 100 хувь тооллогод хамруулсан.

4 сарын 6-ны өдөр сумдын татварын байцаагч нарын нэгдсэн сургалтанд оролцож тооллогын талаарх мэдээллийг өгч хамтран ажиллах үүрэг, чиглэлийг өгч





ажиллаа. Сумдад тооллого явуулахад татварын байцаагчийн оролцоо их байгаа тул чиглэл өгснөөс хойш тооллогын ажил эрчимжиж үр дүнгээ өгсөн. Сумдын бүх шатны засаг дарга нарт аймгийн засаг даргын захирамжаар үүрэг, чиглэл өгөгдсөн тул шаардлагатай шатахуун, ажлын байр, тоног төхөөрөмж, унаа тэргийг орон нутгаас гарган тооллогыг явуулж байна.



**Дөрөв.** Тооллогын талаар иргэдэд зарлал мэдээллийг Дундговь телевиз, Цоглог телевиз, Дундговийн амьдрал сонингоор дамжуулан 20 хоногийн турш өгч явцын талаарх мэдээллийг мөн тухай бүр өгч байлаа. Аймгийн хэлтэс агентлагийн дарга нарын шуурхай цуглаанд долоо хоног бүр явцын мэдээ өгч ажилласан.

Тоологч нартай ажил гүйцэтгэх гэрээг хуулийн дагуу хийж ажил үүргийн хуваарь, урамшуулал, зардлын талаарх мэдээллийг өгч өдөр тутмын удирдлагаар ханган ажилласан байна.

**Тав**. Сумдын улсын бүртгэл статистикийн ажилтнууд аймгийн төвд ирж тооллогын маягт материал, тайлан, илтгэх хуудсаа өгч ажлаа дүгнүүлсэн. УБСГазрын зүгээс идэвх санаачлагатай ажил үүргээ гүйцэтгэсэн сумдыг шалгаруулан

урамшуулахаар шийдвэрлэсэн тул гүйцэтгэлээр байр эзлүүлэхэд Луус, Дэрэн, Сайхан-Овоо, Адаацаг, Гурвансайхан сумд эхний байруудыг эзэлж орон нутгаасаа дэмжлэг авч түргэн хугацаанд тооллогыг гүйцэтгэсэн байна.

**Зургаа**. Аймгийн төвд тоологчоор томилогдсон гэрээт ажилтнуудын ажлыг дүгнэж, эрчимжүүлэх чиглэл өгч өдөр бүр заавар зөвлөмж өгч, тухайн өдрийн ажлын үр дүнг тооцож ажиллаж, гэрээг дүгнэн гүйцэтгэлээр ажлын хөлсийг олголоо. Мөн online хурлын мэдээллийг статистикийн хэлтсийн албан хаагчдад танилцуулж ажил үүргийг хуваарилан мэргэжилтнүүдийг тооллогод татан оролцуулж эрчимжүүлэх арга хэмжээ авч ажилласан.

**Долоо**. Аймгийн хэмжээнд тооллогын ажилд бүх шатны засаг дарга нар дайчлагдаж харилцаа холбооны зардлыг хариуцаж, интернэт, тоног төхөөрөмж, өрөө тасалгаа, унаа машинаар хангаж ажилласан бөгөөд аймгийн дүнгээр нийт **1105.5** мянган төгрөгийн зардал гаргаж ажилласан дүнтэй байна.

**Найм.** Аймгийн хэмжээнд тооллогын ажлыг 4 сарын 20-ны дотор хийж гүйцэтгэхээр төлөвлөсний дагуу ажиллаж дээрх хугацаанд гүйцэтгэлийг 95.2 хувьтай гүйцэтгэсэн болно. Шивэлтийн эрх ирснээс хойш хэлтсийн мэргэжилтнүүд илүү цагаар ажиллан 25-ны өдөр гэхэд тооллогын ажлыг 100 хувь дуусгаж улсад эхний байранд орж амжилттай хийж хэрэгжүүлсэн.

Аймгийн хэмжээнд нийт хүрээгээр ирсэн 826 газраас татан буугдсан 38, бусад шалтгаантай 2 газраас бусад 786 газар бүрэн тоологдсон. Нэмэлт хүрээгээр ирсэн ААНБ-уудаас шинээр нэмж 35 ААНБ, 66 салбарыг тооллогод хамруулж, нийт 887 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсан ба шалтгаантай 40 газрын шалтгааныг тодруулж програмд оруулж, мөн нэмэлт хүрээгээр ирсэн байгууллагуудын шалтгааныг тодруулж, тайлбарыг УБСЕГ-н ТСМГ-ын ахлах мэргэжилтэнд хүргүүлсэн болно.

## 3. ААНБ-ЫН 2015 ОНЫ ӨРТӨГ ЗАРДЛЫН СУДАЛГАА

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “б”-д заасны дагуу Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар нь Салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгтийг байгуулах судалгааг 5 жил тутам явуулж ирсэн.

Энэ удаагийн судалгааг 6 сарын 1 нээс 7 сарын 8 ны хооронд зохион байгуулахаар болж 5 сарын 30 ны өдөр УБСЕГ-аас зохион байгуулагдсан онлайн сургалтанд сууж, судалгаа явуулах маягт, заавар аргачлалтай танилцаж, зарим тодруулах зүйлийг УБСЕГ-ын мэргэжилтнүүдтэй ярьж, зөвлөгөө авч ажиллалаа.

05 р сарын 31 ний өдөр статистикийн хэлтсээс салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгтийг байгуулах судалгаанд сонгогдсон нягтлан бодогч нартай НАХ-ын судалгаа болон хамтран ажиллах, мэдээлэл солилцох талаар кофе-тэй уулзалт, ярилцлага зохион байгууллаа.

Уулзалтанд аймгийн төвийн 38 аж ахуйн нэгжийн 20 гаруй нягтлан бодогч нар оролцлоо. Уг сургалтанд газрын дарга Н.Түвшинжаргал, хэлтсийн дарга Ж.Өлзийжаргал, хэлтсийн ажилтнууд, аймгийн санхүү төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн С.Адъяасүрэн нар оролцлоо.

Салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгтийг байгуулах судалгаанд хөдөөгийн 9 сумын 18 аж ахуйн нэгж сонгогдсон тул сумдын бүртгэгч, төрийн сангийн мэргэжилтэн нарт маягтуудыг хувиарлан өгч, судалгааг гаргах талаар зааварчлага өглөө.

Мөн сумдад 6 сарын 10 ны дотор уг судалгааг дуусгах талаар албан тоотийг гаргаж цахимаар хүргүүллээ.



ДУНДГОВЬ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН
ГАЗАР

48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг,
ЗДТГ-ын байр, Утас/Факс: (976) 7059 2435,
E-mail: dundgovi@nso.mn, dundgovi@burtgel.gov.mn,
http://www.dundgovi.nso.gov.mn

2016.05.31 № 2/481

танай ______ -ны № ______ -т

СУМДЫН БҮРТГЭГЧ, СТАТИСТИКИЙН
АЖИЛТАН НАРТ

Монгол улсын статистикийн тухай хуульд заасанаар Аж ахуйн нэгж байгууллагаас 5 жил тутам НАХ-ын судалгаа авдаг. Энэ жил тус аймгаас 56 Аж ахуйн нэгжээс судалгааг авах түүвэр ирсэн байна. Энэхүү судалгаа нь маш дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан томоохон хэмжээний ач холбогдол бүхий судалгааны нэг тул хавсралтад заасан сумдын ажилчид 06 дугаар сарын 10-ны дотор батлагдсан маягтаар үнэн зөв мэдээлэл ируулэхийг үүгээр мэдэгдэж байна.

Жич: Дараагийн ажлууд цаг хугацааны хувьд шахагдаж байгаа тул түргэн шуурхай арга хэмжээ авч ажиллахыг сануулъя.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н. ТҮВШИНЖАРГАЛ



Судалгаанд хамрагдах Аж ахуйн нэгжийн тоо

| № | Сумын нэр | ААН-ийн тоо | Хариуцах албан хаагч |
|---|---|---|---|
| 1 | Дэрэн | 4 | Г.Баясгалан |
| 2 | Гурвансайхан | 2 | С.Доржханд |
| 3 | Өндөршил | 1 | С.Доржханд |
| 4 | Баянжаргалан | 2 | С.Доржханд |
| 5 | Эрдэнэдалай | 2 | Б.Энхтуяа |
| 6 | Дэлгэрхангай | 2 | Б.Энхтуяа |
| 7 | Адаацаг | 1 | Т.Бямбасүрэн |
| 8 | Дэлгэрцогт | 2 | Т.Бямбасүрэн |
| 9 | Хулд | 2 | Т.Бямбасүрэн |

СХТ, НАХ-ийг байгуулах судалгаанд УБСЕГ-аас сонгогдон ирсэн 56 аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжилтнүүдэд хувиарлан өгч, судалгааг 6 сарын 25 ны дотор авч дуусгах талаар зөвлөгөө өгч ажилласан.

Салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгтийг байгуулах судалгааг орон нутагт зохион байгуулахад УБСЕГ-аас 1,633,394 төгрөгийн зардал ирсэнийг зориулалтын дагуу зарцууллаа.

Дэрэн, Дэлгэрцогт суманд мэргэжилтэн Бямбасүрэн, Баясгалан нарыг ажиллуулж, судалгаануудыг ААН байгууллагын эзэн, ня-бо нартай уулзаж судалгааг бүрэн бөглүүлж авсан. Бусад хөдөөгийн 7 сумын 13 аж ахуйн нэгж байгууллагын мэдээг улсын бүртгэл, статистикийн ажилтан, төрийн сангийн мэргэжилтэн нараар дамжуулан маягт зааврыг өгсөн. Зарим ААНБ-ын нягтлан, захирлуудтай мэйлээр холбогдож, маягтуудыг өгч, судалгааг бүрэн гаргуулан авсан болно. Ихэнх ААН байгууллагууд өөрсдийн дотооддоо хэрэглэдэг бичиг хэргийн зардал, цэвэрлэгээний зардлыг тайландаа тусгай тусгадаггүй, өртгөндөө оруулан тооцдог байсан тул тэр зардлуудыг өртгөөс нь салгаж тусгуулсан.

СХТ, НАХ-ийг байгуулах судалгаанд УБСЕГ-аас сонгогдон ирсэн 56 аж ахуйн нэгж, байгууллагаас “ТЭМТЭЛ” ХХК нь Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн харъяа

байгууллага байсан учир УБСЕГ-т хэлж солиулан, Эрдэнэдалай сумын Далайн дэвжих аривжих ХХК-г судалгаанд хамруулахаар болж, судалгаанд сонгогдсон 56 ААНБ-ын мэдээллийг сонгогдсон маягтуудаар бүрэн цуглуулж дуусган 6 сарын 27 ны өдөр УБСГ-ын мэргэжилтэн Энх-Амгалангаар шалгуулж, зарим тодруулах зүйлийг тодруулан 6 сарын 30 ны өдөр хүлээлгэн өглөө.

Судалгааны явцад СХТ, НАХ-ын явцын мэдээг долоо хоног бүр өгч ажилласан.

## 4.ХАА-Н ӨРТӨГ, ЗАРДЛЫН СУДАЛГАА

Монгол Улсын "Статистикийн тухайхууль"-ийн 7 дугаар зүйл 1 дүгээр хэсгийн в, л дэх заалтын дагуу Хагас жилийн малын түүвэр судалгаа, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого, зардлын судалгааг Дундговь аймгийн Бүртгэл, статистикийн газар 6 дугаар сарын 15-22-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд нийт 15 сумын 1253 өрх, 6 ААН сонгогдож судалгаа авахаас 1247өрх, 6 ААН-ээс судалгаа авлаа. Баянжаргалан, Өндөршил сумын нэг, Говь-Угтаал сумын хоёр өрх буюу нийт 4 өрхтэй холбоо барьж, хүрч чадаагүйгээс судалгаа аваагүй. Мөн Цагаандэлгэр сумын 4201530801821 өрхийн бүртгэлийн дугаартай Н.Өлзиймаа, Адаацаг сумын 4804570105521 өрхийн бүртгэлийн дугаартай С.Дорждэрэм гэсэн 2 өрх шилжсэн тул мэдээлэл авсангүй. Судалгаанд аймгийн хэмжээнд 98.9 хувьтай хамрагдлаа. Сумдууд тооллогыг хугацаанд нь мэдээллээ цуглуулж мөн онлайн програмд хэлтсээс өгсөн хугацаанд шивж дууссан.

Харин МАА-н өртөг зардлын судалгаан дээр бүх баг өрхийн зардлуудыг мянган төгрөгөөр тавиагүй байсан. Багуудын маягтыг шивсэн материалтай тулгаж, өрхүүдийн зардлыг мянгачлаагүй оруулсаныг засуулсан.

## 5.УЛААНБУРХАН, УЛААНУУД ӨВЧНИЙ ЭСРЭГ ДАРХЛАЛ ТОГТЦЫН СУДАЛГАА

Үндэсний статистикийн хороо нь Эрүүл мэндийн яамтай хамтран "Улаанбурхан, улаануud өвчний эсрэг дархлал тогтцын судалгаа"-г ДЭМБ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр орон даяар зохион байгуулан явууллаа.

Судалгааны гол зорилго нь үндэсний болон бүсний түвшинд 6 сартайгаас 35 насны хүн амын дундах улаанбурхан, улаануud өвчний эсрэг дархлал тогтцын түвшинг тодорхойлох явдал юм.

Судалгааг өрхөд суурилан хийх бөгөөд улсын хэмжээнд нийт 6030 өрхийг хамруулан явуулах ба үүнээс Дундговь аймагт Дэлгэрхангай сумын Толь баг, Эрдэнэдалай сумын Сангийн далай баг, Хулд сумын Уул баг, Сайнцагаан сумын Мандал баг, Дэрэн сумын Саруул баг, Говь-Угтаал сумын Морьт баг зэрэг 6 сумын, 6 багийн 282 өрх хамрагдлаа.

Тус судалгааг 11 сарын 16-наас 12 сарын 02-ны хооронд явуулж дууслаа.

Судалгааны ахлагчаар Статистикийн хэлтсийн дарга, 6 нэгжид 4 судлаач, 6 сувилагч, 6 хөтөч, 4 жолооч нийт 21 хүн ажиллалаа. Судлагааны удирдамж болон зохион байгуулалтын талаар Аймаг, сумдын засаг дарга нарт болон албан

байгууллагын дарга нарын цуглаан дээр АЗДТГ-ын харъяа агентлагуудад тухай бүрт нь танилцуулж байсан.

Судалгааны багууд судалгаагаа эхлэхдээ сумдын удирдлагууд, Статистик мэдээ хариуцсан төрийн сангийн мэргэжилтэн, сум дундын эрүүл мэндийн төвийн эрхлэгч, багийн Засаг дарга нартай уулзаж ажлаа танилцуулан, багийн Засаг даргаар маршрут гаргуулан ажиллалаа. Хөдөө сумдад ажиллахдаа хөдөөгийн айлуудад 5-7 өдөр, сумын төвд 2-4 өдөр  ажиллаж нийт 279 өрх ба 249 хүнийг хамруулж, сонгогдсон 6 сартайгаас 35 хүртлэх насны 242 хүнээс сорьц авсан бөгөөд хугацаанд нь сумын лаборторид хүргэж ажилласан.

Судалгаанд сонгогдсон оролцогчидоос Эрдэнэдалай, Хулд сумдад цусны сорьц өгөхөөс татгалзсан хүн гараагүй бөгөөд сонгогдсон хүн бүрээс зөвшөөрлийн хуудас бөглүүлэн, сувилагч цусны дээж авч судлаач асуулгыг асуун сорьц авсан цаг минутыг дор бүр тэмдэглэн,  асуулгын төгсгөлд ЭМ сайдын гарын үсэг бүхий талархлын хуудаст сувилагч, судлаач хоёрын утасны дугаарыг бичиж талархалаа илэрхийлэн ажилласан бөгөөд өрх бүрт 10000 төгрөгийн нэгжийг өгч гарын үсэг зуруулан авч баримтаа бүрдүүлэв.

Судалгааны явцын тайланг судлаачид 2 хоног тутамд судалгааны ахлагчид утсаар мэдээлж, ахлагч нэгтгэж 3 хоног ба 7 хоног тутамд ҮСХ руу цахимаар тайланг хүргүүлж байсан.





Мөн өвлийн улирал  эхэлсэнтэй холбогдуулан айл өрхүүд өвлийн идшээ хийн хөдөө явах, ажил ихтэй байх сонгогдсон гишүүн эзгүй явах бага насны хүүхдийн цус гарахгүй удах зэрэг хүндрэлүүд нилээд тохиолдсон ба зарим айлд 2-3 удаа давтан очиж цусны сорьцыг авч байлаа. Хөдөөний өрхүүдээр явж байх явцад сумын төв дээр сургуулийн дотуур байр, болон айлд суудаг хүүхэд нь сорьц өгөхөөр сонгогдсон ба малчин өрхүүд өөр аймаг, сум, багийн нутагт отроор явсан байсан тул тэдгээр айлуудаар очиж судалгааг авсан болно. Сумаас өөр газарт амьдарч байгаа гишүүд сонгогдсон тохиолдолуудад судлаач нар судалгааны ахлагчид тухай бүр мэдэгдэн

ахдагч ҮСХ-руу цахимаар мэдээллийг хүргүүлж байв. Нийт хамрагдах ёстой 282 өрхөөс 279 өрх хамрагдсан ба 3 өрх УБ хотод байсан. Мөн хамрагдах ёстой 256 хүнээс 242 хамрагдсан ба 7 хүн татгалзаж, УБ-т 4, Өмнөговьд 1, Эрдэнэтэд 1, Дарханд 1 байсан тул ҮСХ-нд мэдээллийг хүргүүлсэн болно. Судалгаанд хамрагдаж сорьц өгөхөөс татгалзсан шалтгаануудаас дүгнэлт хийхэд сувилагчийн чадвар, туршлагаас болон тухайн хүний амьдрал, эрүүл мэндийн нөхцлөөс шалтгаалж байна гэж үзэж болохоор байна.

Судалгаанд нийт 11,133.4 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс отор нүүдэл ихтэй байгаан улмаас шатахууны зардал өндөр гарч 13,669.4 мянган төгрөг зарцуулагдсан болно.

Судалгааны явцад буюу 11 сарын 29-30-нд ҮСХ-ны судалгаа хариуцсан мэргэжилтэн И. Энхбаатар, ХӨСҮТ-ийн дархлаажуулалт хариуцсан их эмч М.Энхтуяа нар хяналтаар ирж Сайнцагаан, Хулд, Дэлгэрхангай сумдад ажилласан ба судалгааны ахлагч болон судлаач хамт явж ажилласан билээ. Дээрх сумдад хяналтаар ажиллахдаа Аймгийн ЭМГ-ын дарга Ц.Энхсайхан, дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн Саруулцэцэг болон сумдын удирдлагууд, сумдын ЭМТ-ийн дарга, судалгаанд ажилласан сувилагч, лаборант нартай уулзаж судалгааны явцын талаар давуу талууд болон хүндрэл бэрхшээлийг ярилцлаа.





Улаанбурхан, Улаанууд өвчний эсрэг дархлал тогтцын судалгаа нь ДЭМБ, МУЗГ-тай хамтарсан судалгаа бөгөөд ҮСХ-той хамтран зохион байгуулсан, мөн цусны сорьц авч байгаа хамгийн анхны судлагаа бөгөөд уг судалгаа нь манай орон нутагт амжилттай болж дууслаа. Аймгийн ЭМГ болон Статистикийн хэлтсийн ажилчид судалгаанд хариуцлагатай, чадварлаг оролцож орон нутгийн иргэдэд судалгааны ач холбогдол, мэдээллийг үнэн зөв хүргэсэн учраас иргэд идэвхитэй оролцсон байна.

Манай аймгийн хэмжээнд судалгаанд нийт 282 өрх хамрагдахаас 279 өрх хамрагдсан ба өрхийн хэмжээнд хамрагдалт 98,9 хувьтай, санамсаргүй түүврийн аргаар 256 хүн сонгогдож хамрагдах ёстойгоос 7 хүн өөр аймаг хотод амьдарч байгаа учраас тус орон нутаг руу нь шилжүүлж, 249 хүнээс 7 татгалзаж 242 хүн буюу 97,2 хувьтай хамрагдаад байна.




Судалгааны үр дүнд уг судалгааны арга аргачлалыг Дэлхийн хэмжээнд ба улс орондоо цаашид өөр судалгаанд ашиглах боломжтой бөгөөд энэ судалгаагаар улс орныхоо эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг сайжруулж болохоор, тус 2 байгууллагын чадварлаг, туршлагатай боловсон хүчнийг ашиглан аливаа өвчлөлийн асуудлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч болохуйц ач холбогдолтой судалгаа боллоо гэж дүгнэж байна.

## III БҮЛЭГ. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ, СУРГАЛТ,

### 10. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА (Ш10)

2016 онд зохион байгуулах сургалт семинарын нэгдсэн графикийг хэлтсийн даргаар батлуулан, графикийн дагуу сургалтыг зохион байгуулаад байна.

БАТЛАВ. УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ГАЗРЫН
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ж.ӨЛЗИЙЖАРГАЛ

2016 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТ, СЕМИНАРЫН НЭГДСЭН ГРАФИК

| д/д | Сургалт семинарын нэр | Оролцох хүн | Хугацаа | Хэд хоног | Оролцох хүний тоо | Зохион байгуулах ажилтан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Статистикийн салбарын эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, статистикийн мэдээ тайлан гаргах аргачлал, анхан шатны бүртгэл хөтлөх арга зүй | Сум багийн статистик мэдээ хариуцсан ажилтнууд | 3, 6, 12 сард | 6 | 81 | Ж.Өлзийжаргал ажилтнууд |
| 2 | ААНБ-ын тооллогын хууль эрх зүйн үндэс, тооллогын тов, зорилго, ач холбогдол, асуулгын маягтуудыг нөхөх зааварчлага, ААНБ-ыг газрын зурагт тэмдэглэх, | сумдын бүртгэл, статистикийн мэдээ хариуцсан ажилтнууд, | 3 р сард | 2 | 30 | Ж.Өлзийжаргал Г.Баясгалан |
| 3 | Албан ёсны статистик мэдээний маягт, заавар аргачлал, мэдээ тайлан гаргахад анхаарах асуудлууд, статистик мэдээллийн нэгдсэн сангийн тухай, | ААНБ-ын ня-бо нар | 4, 12 сард | 2 | 50 | Ж.Өлзийжаргал ажилтнууд |
| 4 | Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтийг тооцох аргачлал, заавар | Хөдөлмөрийн хэлтэс | 3 сард | 1 | 15 | С.Доржханд |
| 5 | Статистикийн мэдээллийг хэрхэн ашиглах, мал тооллогын ажлыг орон нутагт зохион байгуулах талаар зааварчлага өгөх | Сумдын удирдлага, түшмэлүүд | 6.12 сард | 2 | 50 | Ж.Өлзийжаргал, ажилтнууд |
| 6 | Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал, статистикийн мэдээллийг хэрхэн ашиглах талаар | Албан газрын удирдлага, ахмадууд | улиралд | 4 | 50 | Ж.Өлзийжаргал, ажилтнууд |
| 7 | Сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх, шинээр батлагдан гарсан дүрэм, журмыг таниулах, улсын бүртгэл, статистикийн үйл ажиллагаатай холбоотой анхаарах асуудлууд | улсын бүртгэл, статистикийн ажилтан | 5 сард | 2 | 40 | Ж.Өлзийжаргал УБСГ-ын ажилтнууд |
| 8 | Статистикийн тухай хууль, бүтэц зохион байгуулалт болон статистикийн тоо, мэдээллийг ашиглах нь | МСҮТ-ийн сурагчид | 9.11 сард | 2 | 40 | Б.Энхтуяа, Т.Бямбасүрэн |
| 9 | Статистикийн боловсрол олгох | ЕБС-ийн сурагчид | 11 сарын 11 | 1 | 35 | Ж.Өлзийжаргал |

**Нэг.** Дундговь аймгийн УБСГ--аас 2016 оны 03 сарын 30-31-ны өдрүүдэд аж ахуй нэгж, байгууллагын улсын тооллогын тоологч, шалгагч нарыг бэлтгэх нэгдсэн сургалтыг Аймгийн ЗДТГ-ын хурлын зааланд амжилттай зохион байгууллаа.




Уг сургалтанд сумдын бүртгэл статистикийн ажилтан, төрийн сангийн мэргэжилтнүүд болон хэлтсийн ажилтнууд оролцлоо

Сургалтыг аймгийн УБСГ-ын дарга Н.Түвшинжаргал нээж, Статистикийн хэлтсийн дарга Ж.Өлзийжаргал хөтөлбөрийн дагуу удирдан зохион байгуулж, тооллогын хууль эрх зүйн үндэс, тооллогын тов, зорилго, ач холбогдол, явуулах арга хэлбэр, тоологч, шалгагч нарын үүрэг, баримтлах зарчмын талаар тодорхой зааварчлага өглөө.




Тус сургалтанд бизнес регистрийн сан хариуцсан ажилтан Г.Баясгалан, бүртгэлийн хэлтсийн дарга Ш. Нарангэрэл, хуулийн этгээдийн бүртгэгч Б.Одонтунгалаг нар оролцож ААНБ-ын тооллогын асуулгын маягтуудыг нөхөх зааварчлага, ААНБ-ыг газрын зурагт тэмдэглэх талаар нэг бүрчлэн зааж, иргэний улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлууд, иргэний бүртгэлийн сан болон ХАӨМС-ын тулгалт, хуулийн этгээдийн бүртгэл, тооллоготой холбоотой мэдээлэл өглөө.

Мөн сургалттай холбоотой асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, УБСГ-ын дарга Н.Түвшинжаргал сумдын бүртгэл статистикийн ажилтантай гэрээ байгуулж, хамт олноороо зургаа татууллаа.



Сургалтанд хамрагдах ёстой ажилтнууд 100 хувь хамрагдсан бөгөөд сургалтанд оролцогчдод аж ахуй нэгж байгууллагын тооллогын асуулга нөхөх заавар, тооллогын маягт, зар сурталчилгааны баннер, тоологч, шалгагчын үнэмлэх, сургалтын материал, ААНБ-ын хүрээг өгч, тооллогыг чанартай сайн зохион байгуулахад амжилт хүсч, сургалтын үйл ажиллагаа өндөрлөлөө.

Аймгийн төвд 3 тоологч шинээр авч ААНБ-ын тоооллоготой холбоотой бүх асуудлаар хичээл зааж сургалаа. Мөн УБСЕГ-аас зохион байгуулсан програмын сургалтанд статистикийн хэлтсийн бүх ажилтнууд, аймгийн төвийн тоологч нар сууж, програмын талаар зохих мэдлэгтэй боллоо.

Сургалтын тайланд сургалтын хөтөлбөр, ирцийн бүртгэл, явцын зураг, тараах материал, сургалтын материалыг хавсаргалаа.

**Хоёр**. Дундговь аймгийн УБСГ-ын статистикийн хэлтсийн төлөвлөгөөнд тусгасны дагуу төсөвт байгууллага, аж ахуйн нэгжүүдийн нягтлан бодогч нарт зориулсан сургалтыг 2016 оны 4 р сарын 7 ны өдөр аймгийн тамгын газрын 1 давхрын зааланд зохион байгууллаа. Сургалтыг УБСГ-ын статистикийн хэлтсийн дарга Ж.Өлзийжаргал нээж, ААНБ-ын тооллогын хууль эрх зүйн үндэс, тооллогын тов, зорилго, ач холбогдол, явуулах арга хэлбэрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө. Мөн хэлтсийн ажилтан Г.Баясгалан ААНБ-ын тооллогын асуулгын маягтуудыг нөхөх зааварчлага, ААНБ-ыг газрын зурагт үнэн зөв тэмдэглэх, онлайнаар бүртгүүлэх талаар зааварчлага өглөө. Мөн сургалтанд аймгийн төвд ажиллаж байгаа тоологч нар оролцлоо.

Статистикийн мэдээ, тайлан гаргахад анхаарах асуудлууд, статистик мэдээ, мэдээллийг хаанаас авах, статистик мэдээллийн нэгдсэн сангийн тухай, хэлтсийн дотоод мэдээлэл зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгууллаа. Сургалтанд нийт давхардсан тоогоор 82 аж ахуй нэгж байгууллагын 49 нягтлан бодогч хамрагдлаа.







Тасвийн болон аж ахуй нэгжийн нягтлан бодогч нарын сургалтын ирц бүртгэл

Мандалговь 2016.04.07

| № | Овог нэр | Албан байгууллага, аж ахуй нэгжийн нэр | Холбоо барих утас | Цахим шуудангийн хаяг | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|

Сургалтанд ирсэн ААНБ болон төсвийн байгууллагын ня-бо нарыг улсын бүртгэлийн гэрчилгээ, 2015 оны балансаа харж онлайнаар болон цаасаар бүртгэлд хамрагдахыг уриаллаа.

**Гурав.** Дундговь аймгийн Улсын бүртгэл статистикийн газраас 2016 оны 5 сарын 23-24-ны өдөр орон нутаг дахь улсын бүртгэл, статистикийн ажилтнуудад зориулсан сургалтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтанд УБСЕГ-ын УБХ-ын иргэний бүртгэлийн хэлтсийн дарга Д.Энхцэцэг, Үндэсний тооцооны хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Мөнхзул нар ирж хамтран зохион байгууллаа.

Сургалтыг Аймгийн засаг дарга С.Од-Эрдэнэ нээж, УБСЕГ-ын УБХ-ийн иргэний бүртгэлийн дарга Д.Энхцэцэг, аймгийн УБСГ-ын статистикийн хэлтсийн дарга Ж.Өлзийжаргал нар удирдан хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа.





Сургалтын хөтөлбөрийн дагуу “Сонгуулийн тухай хууль”, “Сонгогчийн нэрсийн жагсаалт үйлдэх, танилцуулах, давхардлыг шалгах, сонгогч шилжих журам”, “Сонгуулийн бэлтгэл ажилд анхаарах асуудал “Бүртгэл, статистикийн үйл ажиллагаа, сумын бүртгэгч, статистикийн ажилтны чиг үүрэг”, “Иргэний бүртгэлийн мэдээллийн сан болон ХАӨМСангийн тулгалт, анхаарах асуудал”, “Хүн ам, нийгэм, эдийн засгийн статистикийн мэдээлэл цуглуулалт, анхаарах асуудал“, “Хүн ам, өрхийн мэдээллийн сан, мал тооллогын мэдээллийн сан, ХАА-н статистикийн мэдээлэл дамжуулах програм, ХАА-н мэдээний гаргалт, анхаарах асуудал”, “Статистикийн мэдээллээр үйлчлэх сангийн хэрэглээ, ашиглалт www.1212.mn,”,





“УБСГ-ын авилгын эсрэг 2016 оны төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх”, ”ААНБ-ын улсын тооллого явуулсан тухай тайлан”, ”Сонгуулийн хуулийн бэлтгэл ажлын явцын талаар танилцуулга”, ”УБСГ-ын ажлын байрны тодорхойлолт, дотоод ажил”, “УБСангаас төвд мэдээлэл дамжуулах програм”, ”Хүний эрхийн тухай ойлголт”, “ЭМД-ын тухай хуулийн шинэчлэлт” сэдвүүдийн хүрээнд УБСЕГ-ын УБХ-ийн иргэний бүртгэлийн дарга Д.Энхцэцэг, ҮТХэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Мөнхзул, аймгийн УБСГ-ын статистикийн хэлтсийн дарга Ж.Өлзийжаргал, мэргэжилтэн С.Доржханд, Б.Энхтуяа, аймгийн УБСГ-ын УБХ-ийн дарга Ш.Нарангэрэл, УБХ-ийн иргэний бүртгэлийн ахлах бүртгэгч Б.Сайхантуяа, мэдээлэл технологийн ажилтан Э.Адъяабаатар, Хүний эрхийн үндэсний комиссын Дундговь дахь салбарын ахлах мэргэжилтэн Т.Баярцэцэг, НДХ-ийн хяналтын байцаагч Х.Энхжаргал нар хичээл заалаа. Сургалтын дараа ярилцлага зохион байгуулж, оролцогчдын сонирхсон асуултанд хариулж санал бодлоо солилцлоо





.

Тус сургалтанд сумдын улсын бүртгэл статистикийн ажилтнууд, аймгийн УБСГ-ын ажилтнууд нийт 30 гаруй хүн хамрагдан сургалтын ирц, хамрагдалт, идэвх оролцоо хангалттай сайн байлаа.

Сургалтын дараа тус сургалттай холбоотой үнэлгээний хуудас бөглүүлж авсан бөгөөд тэдгээрийг нэгтгэхэд сургагч багш нарын ур чадвар маш сайн, сургалт бүрэн ойлгомжтой, сайхан сургалт боллоо. Сонгуулийн хуулийн тухай, УБСЕГ-ын дүрэм, журам, иргэний бүртгэлийн талаар анхаарах чухал асуудлууд зэргийг маш ойлгомжтой заалаа. Мөн статистикийн мэдээ тайлан гаргах, мэдээллийн сангийн талаар өргөн мэдлэг хуримтлуулж, авъя гэсэн мэдлэгээ маш сайн олж авсан гэсэн үнэлгээ өгсөн байна.

Сургалтыг сайжруулахталаархи санал, дараа ямар сургалтанд хамрагдах хүсэлт:

1. Зохион байгуулалтыг илүү сайжруулах
2. Сургалтын хугацааг урьдчилан тодорхой мэдээлэх

3. Хууль эрх зүйн дагнасан сургалт, тухайлбал Иргэний хууль гэх мэт
4. Хуулийн этгээд, ЭХЭБ талаар

Тус аймгийн УБСГ-аас зохион байгуулсан орон нутаг дахь улсын бүртгэл статистикийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт үр дүнтэй, ач холбогдолтой сургалт болж өндөрлөлөө.

**Дөрөв**. 2016 оны 05 р сарын 31 ний өдөр статистикийн хэлтсээс салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгтийг байгуулах судалгаанд сонгогдсон нягтлан бодогч нартай НАХ-ын судалгаа болон хамтран ажиллах, мэдээлэл солилцох талаар кофе-тэй уулзалт, ярилцлага зохион байгууллаа.

Уулзалтанд аймгийн төвийн 38 аж ахуйн нэгжийн 20 гаруй нягтлан бодогч нар оролцлоо. Уг сургалтанд газрын дарга Н.Түвшинжаргал, хэлтсийн дарга Ж.Өлзийжаргал, хэлтсийн ажилтнууд, аймгийн санхүү төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн С.Адъясүрэн нар оролцлоо.

Газар, хэлтсийн дарга нар салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгтийг байгуулах талаар статистикийн тухайМонгол Улсын хуулийн заалт, уг судалгааны ач холбогдол, судалгааны үр дүнд үндэслэн нөөц, ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцлийг 2015 оны гүйцэтгэлээр байгуулах, статистикийн мэдээ, тайлан гаргахад анхаарах асуудлууд, статистик мэдээллийг хаанаас авах, статистик мэдээллийн нэгдсэн сангийн тухай, газар, хэлтсийн дотоод мэдээллийн талаар товч танилцууллаа.

Хэлтсийн мэргэжилтнүүд судалгааны маягтуудыг нэг бүрчлэн зааж, судалгааг 6 сарын 20 ны дотор хийж дуусгах талаар зөвлөлөө. Мөн санхүү, төрийн сангийн мэргэжилтэн С.Адъясүрэн нягтлан бодогч нарт хамтран ажиллаж судалгааг чанартай сайн хийх талаар зөвлөгөө өглөө.







Салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгтийг байгуулах судалгаанд хөдөөгийн 9 сумын 18 аж ахуйн нэгж сонгогдсон тул сумдын бүртгэгч, төрийн сангийн мэргэжилтэн нарт маягтуудыг хувиарлан өгч, судалгааг гаргах талаар зааварчлага өглөө.

Мөн сумдад 6 сарын 10 ны дотор уг судалгааг дуусгах талаар албан тоотийг гаргаж цахимаар хүргүүллээ.



ДУНДГОВЬ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН
ГАЗАР

48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар бег, ЗДТГ-ын байр. Утас/Факс: (976) 7059 2435.
E-mail: dundgovi@nso.mn, dundgovi@burtgel.gov.mn,
http://www.dundgovi.nso.gov.mn

2016.05.31 № 2/481

танай ____________-ны №____________-т

СУМДЫН БҮРТГЭГЧ, СТАТИСТИКИЙН
АЖИЛТАН НАРТ

Монгол улсын статистикийн тухай хуульд заасны дагуу Аж ахуйн нэгж байгууллагаас 5 жил тутам НАХ-ын судалгаа авдаг. Энэ жил тус аймгаас 56 Аж ахуйн нэгжээс судалгааг авах түүвэр ирсэн байна. Энэхүү судалгаа нь маш дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан томоохон хэмжээний ач холбогдол бүхий судалгааны нэг тул хавсралтад заасан сумдын ажилчид 06 дугаар сарын 10-ны дотор батлагдсан маягтаар үнэн зөв мэдээлэл ирүүлэхийг үүгээр мэдэгдэж байна.

Жич: Дараагийн ажлууд цаг хугацааны хувьд шахагдаж байгаа тул түргэн шуурхай арга хэмжээ авч ажиллахыг сануулъя.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н. ТҮВШИНЖАРГАЛ



Судалгаанд хамрагдах Аж ахуйн нэгжийн тоо

| № | Сумын нэр | ААН-ийн тоо | Хариуцах албан хаагч |
|---|---|---|---|
| 1 | Дэрэн | 4 | Г.Баясгалан |
| 2 | Гурвансайхан | 2 | С.Доржханд |
| 3 | Өндөршил | 1 | С.Доржханд |
| 4 | Баянжаргалан | 2 | С.Доржханд |
| 5 | Эрдэнэдалай | 2 | Б.Энхтуяа |
| 6 | Дэлгэрхангай | 2 | Б.Энхтуяа |
| 7 | Адаацаг | 1 | Т.Бямбасүрэн |
| 8 | Дэлгэрцогт | 2 | Т.Бямбасүрэн |
| 9 | Хулд | 2 | Т.Бямбасүрэн |

**Тав. МСҮТ-ийн оюутнуудад хийсэн "Статистикийн тухай мэдлэг, мэдээлэл"сэдэвт сургалтын тайлан /ИДСС/**

Статистикийн хэлтсээс жил бүр зохион байгуулдаг аймгийн МСҮТ-ийн оюутнуудад зориулсан сургалтыг "Статистикийн тухай мэдлэг, мэдээлэл" статистик мэдээллийн нэгдсэн сан зэрэг сэдвийн хүрээнд хийлээ.







Сургалтыг тус коллежийн оёдол эсгүүр, тогооч, нарийн боов, барилгын дотоод заслын төгсөх курсийн 43 оюутнуудыг хамрууллаа. Уг сургалтыг Статистикийн хэлтсийн Аж үйлдвэр худалдаа хариуцсан мэргэжилтэн Г.Ариунжаргал ахлах мэргэжилтэн Ж.Уянга нар удирдан зохион байгууллаа.

Сургалтанд хамрагдсан оюутнууд хэрэгцээтэй зүйлсээ мэдэж авсан тухайгаа санал асуулгад илэрхийлсэн байна. Мөн сургалтанд оролцсон нийт оюутнуудад заасан хичээл болон 2015 оны жилийн эцсийн мэдээ, энэ оны 3 р улирлын мэдээллийг хамруулан статистик мэдээллийн нугалбарыг оюутнуудад тараалаа.

**Зургаа. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургалт явуулсан тухай**

Үндэсний Статистикийн хорооноос жил бүр “Статистикийн боловсрол” сэдэвт хичээлийг ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад Монгол улсад Статистикийн салбар үүсч хөгжсөн ойн өдөр нийслэл, аймаг, дүүрэгт нэгэн зэрэг заадаг уламжлалтай билээ. Энэ ажлын хүрээнд Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Ж.Уянга, мэргэжилтэн Г.Ариунжаргал, гэрээт ажилтан М.Өнөрбаяр нар Говийн Ирээдүй Цогцолбор сургуулийн төгсөх ангийн сурагчдад "Статистикийн боловсрол" сэдэвт хичээл заалаа. Уг сургалтанд тус сургуулийн 12-р ангийн 4 бүлгийн нийт 50 гаруй сурагч хамрагдан Статистикийн тухай ойлголт болон тус мэргэжилийн талаар тодорхой ойлголт авлаа.




**Долоо. Анхан шатны Статистик мэдээ хариуцсан ажилтны сургалт явуулсан тухай**

Дундговь аймгийн Статистикийн хэлтэс нь 2016 оны төлөвлөгөөний дагуу анхан шатны статистик мэдээ хариуцсан ажилтнууд буюу төрийн сангийн мэргэжилтнүүд, сумдын Засаг дарга нар, ИТХ-ын дарга нарт зориулсан сургалтыг 2016 оны 12 сарын 01-ны өдөр Дундговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн 3-р хуралдааны үеэрамжилттай зохион байгууллааСургалтанд сумдын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга, Сайнцагаан сумын багийн Засаг дарга, түүний туслах ажилтан нар, сумдын төрийн сангийн зарим мэргэжилтэн, санхүү албаны дарга нар оролцлоо.

.



Сургалтаар статистикийн салбарын эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт,жилийн эцсийн мал тооллогын зохион байгуулалт, анхаарах асуудал, ХАӨМСан, түүний шинэчлэлт өөрчлөлтөд анхаарах асуудал, Статистикийн тухай хууль болон сум, багийн Засаг дарга нарт холбогдолтой бусад хуулийн заалтууд, цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээлэл,статистик мэдээллийн нэгдсэн сан www.1212.mnтанилцуулга болон түүний хэрэглээ сэдвүүдээр сургалт хийлээ. Сургалтанд хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн нар дээрхи сэдвүүдээр хичээл заалаа.

## 11.СУРТАЛЧИЛГАА (Ш11)

**1.Хэвлэлийн бага хурал /ХБХ/**

Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу сар бүрийн Аймгийн нийгэм, эдийн засгийн танилцуулгаар иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон танхимаар товч мэдээлэл байнга өгч байгаа билээ.

Аймгийн нийгэм, эдийн засгийн гол үзүүлэлтүүдээр танилцуулгыг бэлтгэж, сар бүрийн дараа сарын 10 ны дотор хэвлэж, нийт хэвлэмэл байдлаар сар бүр 10-15 ширхэгийг хэвлэж, аймгийн удирдлага, хэлтэс агентлагийн дарга нарт танилцуулахын зэрэгцээ сар бүрийн 15-ны дотор 11.00 цагаас тус аймгийн Дундговь телевиз, Цоглог телевиз, Дундговийн амьдрал сонин, TV-9 телевизийн орон нутаг дах сэтгүүлч, аймгийн ЗДТГ-н хэлтсүүдийн бие төлөөлөгч нарт аймгийн нийгэм, эдийн засгийн гол үзүүлэлтүүдээр хэвлэлийн бага хурлын танилцуулга бэлтгэж танилцуулж хэвшсэн.

Мөн аймгийн вэб хуудас, фэйсбүүк, твиттер хуудсаар олон нийтэд тархааж ажиллаа.

Хэвлэлийн хурлын үеэр сэтгүүлчдийн сонирхсон асуултанд хариулж мөн Статистик мэлээллийн нэгдсэн сан www.1212.mn сайт болон МонСтат, EzStat аппликейшний талаар мэдээлэл сурталчилгаа хийж, орон нутгийн телевизээр тодруулга мэдээлэл өгч ажиллаа










Төлөвлөгөөний дагуу 2015 оны жилийн эцсийн танилцуулгыг 1-р сарын 15 нд нэгтгэн 100 ширхэгийг хэвлэн аймгийн бүх газар хэлтэс,байгууллага, сумдуудад тархаалаа.

2015 оны жилийн эцсийн мал тооллогын үр дүнгээр танилцуулга бэлтгэн гаргаж, 4 сарын 8-ны өдөр 15 сумын орлогч дарга нар болон ХАА-н мэргэжилтнүүд малчдын төлөөлөл болох нийт 60 гаруй хүн  хамрагдсан сургалтанд ХАА-н  судалгааны талаар танилцуулж хэвлэлийн хурал зохион байгууллаа.





Дундговь аймгийн 2015 оны жилийн эцсийн хүн ам, өрх, нийгмийн гол үзүүлэлтүүдээр  танилцуулгыг бэлтгэн 2016 оны 4 сарын 29-ны өдөр хэвлэн гарлаа.




Дундговь аймгийн "2015 оны өрх, хүн амын төлөв байдал", 2016 оны 4 сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга тараасан жагсаалт

| Д/д | Нэр | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|

ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛ СТАТИСТИКИЙН ГАЗАР

Мөн аймгийн нийгэм, эдийн засгийн  4 сарын танилцуулгатай хамтатган 5 сарын 11 ны өдөр АЗДТГ-ын 1 давхрын зааланд хэвлэлийн бага хурал хийж, хүн ам, өрх,

өрхийн нийгмийн гол үзүүлэлтүүдээр хийсэн танилцуулгыг хэвлэл мэдээллийн ажилтнууд, албан газар байгууллагын удирдлага, мэргэжилтнүүдэд танилцуулж санал бодлыг нь сонсож, олон түмэнд хүргэлээ.






Энэхүү хэвлэлийн бага хуралд Дундговь ТВ, Цоглог ТВ-ийн сэтгүүлч, аймгийн олон нийттэй харьцах албаны мэргэжилтэн АЗДТГ-ын хэлтсийн төлөөллүүд, болон аймгийн ЭМГ, БСГ, Халамжийн газар, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс, УБСГ, хөдөлмөрийн хэлтэс зэрэг албаны хүмүүс оролцлоо.

Аймгийн 2015 оны барилга, аж үйлдвэрийн салбарын үзүүлэлтүүдээр танилцуулгыг бэлтгэн 2016 оны 6 сарын 15-ны өдөр хэвлэн гаргаж, аймгийн нийгэм, эдийн засгийн 5 сарын танилцуулгатай хамтатган 6 сарын 14ны өдрийн 10 цагаас АЗДТГ-ын 2 давхрын зааланд хэвлэлийн бага хурал хийж, барилга, аж үйлдвэр, тээвэр холбоо, бизнес регистрийн сангийн гол гол үзүүлэлтүүдээр хийсэн танилцуулгыг хэвлэл мэдээллийн ажилтнууд, албан газар байгууллагын удирдлага, мэргэжилтнүүдэд танилцуулж санал бодлыг нь сонсож, олон түмэнд хүргэлээ.




Энэхүү хэвлэлийн бага хуралд Дундговь ТВ, Цоглог ТВ-ийн сэтгүүлч, аймгийн олон нийттэй харьцах албаны мэргэжилтэн АЗДТГ-ын хэлтсийн төлөөллүүд, болон бусад сонирхсон албаны хүмүүс оролцлоо.

2015 оны хүн амын ажил, эрхлэлт ажилгүйдлийн танилцуулгыг ажиллах хүчний түүвэр судалгааны үр дүнгээр бэлтгэн графикт хугацаанд нь буюу 6-р сарын 25 ны дотор гарган газрын вэб хуудсанд байршуулж,ажил эрхлэлтын танилцуулгыг 2016 оны 7-р сарын 7 ны 10 цагт аймгийн хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтнүүд, Цоглог ТВ-ийн сэтгүүлч, аймгийн олон нийттэй харьцах албаны мэргэжилтэн АЗДТГ-ын хэлтсийн

төлөөллүүдэд 2016 оны эхний хагас жилийн статистик мэдээний танилцуулгатай хамтатган хэвлэлийн бага хурал хийлээ.





**2. Тооллого, судалгааны сурталчилгаа /ТСС/:**

УБСЕГазраас зохион байгуулсан удирдах ажилтны сургалт семинарт хэлтсийн даргаоролцсон бөгөөд орон нутагт 1, 2-р улиралд УБСЕГ-аас зохион байгуулсан "Орон нутаг дахь улсын бүртгэл, статистикийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт"-д ХАӨМСан Мал тооллого, ХАА-н програмын талаархи хичээлийг зааж сумдаас аймагт хүргүүлэх мэдээ тайлангийн маягт, графикийн талаар заавар зөвлөмж өгч хэлтсийн бүх албан хаагч нар хамрагдлаа.

Мөн Аж ахуйн нэгж байгууллагын улсын тооллого зохион байгуулах аймгийн комисс аймгийн ЗДТГазрын даргын өрөөнд хуралдаж тооллогод зарцуулагдах шатахууны зардалд аймгийн Засаг даргын нөөц сангаас 500000 төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэлээ. Мөн ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг гаргаж аймгийн хэмжээнд тооллогыг эрчимжүүлэх үүргийг бүх шатны байгууллагын дарга, нягтлан бодогч нарт өгч ажиллалаа.

4 сарын 6-ны өдөр сумдын татварын байцаагч нарын нэгдсэн сургалтанд оролцож ААНБ-ын тооллогын талаарх мэдээллийг өгч хамтран ажиллах үүрэг, чиглэлийг өгч ажиллалаа. Сумдад тооллого явуулахад татварын байцаагчын оролцоо их байгаа тул чиглэл өгснөөс хойш тооллогын ажил эрчимжиж үр дүнгээ өгсөн.

НАХ-ын судалгаанд хамрагдсан байгуулагуудын нягтлан нартай ярьж кофе-тэй уулзалт, ярилцлаганд урьж оролцуулан, мэдээллийн маягтыг нэг бүрчлэн зааж зааварчлага өгсөн.

3-р улиралд УБС-ийн ажилтнуудад сургалт зохион байгуулсан төдийгүй 4-р улиралд мал тооллогын сургалтыг зохион байгуулсан.

Мөн 4-р улиралд Улаанбурхан, улаанууд өвчний дархлал тогтцын эсрэг судалгааны мэдээлэл цуглуулалтанд ажиллах ахлагч, судлаач нарын сургалтыг 2016 оны 11 дүгээр сарын 14,15-ны өдрүүдэд ҮСХорооноос онлайнаар зохион байгуулсан болно. Сургалтанд хэлтсийн судлаачаар явах мэргэжилтэн С.Доржханд, Н.Түвшинжаргал, Г.Ариунжаргал, Г.Баясгалан, ахлагч Б.Энхтуяа нар мөн судалгаанд хамрагдсан 6 сумын сувилагч лаборант нар оролцов.

Сургалтаар судлаач нарт зориулсан судалгаа хэрхэн явуулах тухай, анхаарах асуудлууд,программ ашиглалт, зардалтай холбоотой бүрдүүлэх материал, халдварт

өвчин судлалын үндэсний төвөөс хамааралтай зарим сургалтыг сумдуудын сувилагч, лаборант нарт заав.



Энэ жилийн байдлаар цаг үеийн ажлын талаар ҮСХ-оос зохион байгуулсан 9 удаагийн онлайн сургалтанд албан хаагчид бүрэн хамрагдсан байна.
Жилийн эцсийн байдлаар хэвлэлийн бага хурлыг өмнөх оны эцсийн болон тайлант оны 12 сарын байдлаар нийт 12 удаа хийж, 250 ширхэг танилцуулгыг тархааж, web-д байршуулаад байна.

Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүдийн хөдөлгөөний Дундговь дахь салбарын тэргүүн А.Хатантөмөр Авилгын эсрэг хууль тогтоомжийн талаар хэлтсийн ажилтнуудад сургалт зохион байгуулж, ажилтнууд идэвхтэй оролцлоо.





3. **Хэрэглэгчдэд статистикийн мэдээллийн санг сурталчлах /ХСМСС/, хууль болон салбарын үйл ажиллагааг сурталчлах /ХБСҮАС/**

Сар, улирал бүрийн хэвлэлийн бага хурлаар аймгийн Дундговь телевиз, Дундговийн амьдрал сонин, TV-9 телевизийн орон нутаг дах сэтгүүлч, Монцамэ агентлагийн сурвалжлагч нарт болон хэвлэлийн бага хуралд оролцсон Аймгийн ЗДТГ-ын болон бусад хэлтэс, агентлагуудын удирдлагуудад жилийн эцсийн байдлаар нийт 15 удаа Статистик мэлээллийн нэгдсэн сан www.1212.mn сайт болон МонСтат, EzStatаппликейшний талаар мэдээлэл сурталчилгаа хийсэн байна. Мөн аймгийн вэб

хуудас, фэйсбүүк, Дундговь аймгийн байгууллагын цогц мэдээлэл /и-оффисс/ зэргээр олон нийтэд сурталчилж байна.

Аймгийн нийгэм эдийн засгийн гол үзүүлэлтүүдээр динамик бэлтгэн вэб хуудсанд байршуулж, Devinfo мэдээллийн санг бүх салбарын үзүүлэлтүүдээр баяжуулан,энэ онд Devinfo-6.0 програмаар нийт 19 дэд салбарын 90 үзүүлэлтийг сумчлан, 29 үзүүлэлтийг аймгийн дүнгээр шивж оруулан, мэдээллийн санг баяжуулаад байна.

Монгол улсын аж үйлдвэрийн сайдын 2015 оны 193 дугаар тушаал , Аж үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 3-р сарын 10-ны өдрийн 61-р тушаалыг үндэслэн Монгол улсын аж үйлдвэрийн мэдээллийн санг бий болгох зорилгоор явагдсан үйлдвэрлэл эрхлэгчдийн улсын тооллогыг явуулах ажлын хэсэгт орж ажиллаа. Тус тооллого 2016 оны 4 сарын 15-аас 6 сарын 1-ны хооронд үргэлжилсэн юм.

Тооллогын нээлтийн арга хэмжээ 2016 оны 4 сарын 15-ны өдөр 13.00 цагаас улс орон даяар нээлтээ зэрэг хийсэн бөгөөд Дундговь аймагт АЗДТГ-н 1 давхрын зааланд нээлтээ хийсэн юм. Нээлтэнд аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжийн төлөөлөл болох 30 байгууллагын төлөөлөл оролцлоо.

Тус нээлтэнд Статистикийн хэлтсийн аж үйлдвэр, худалдаа хариуцсан мэргэжилтэн Т.Бямбасүрэн үйлдвэрийн мэдээ хэрхэн өгч байх, статистикийн байгууллага үйл ажиллагааны талаар товч мэдээлэл, 2015 оны жилийн эцсийн статистик мэдээллийг тус тус өгсөн.





Үйлдвэрийн улсын тооллого явуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 193 дугаар тушаал, Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 61 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох зорилгоор үйлдвэрлэл эрхлэгчдийн улсын тооллогыг явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Мандсайхан – Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: Д.Энхтуяа - ЗДТГ-ын үйлдвэрлэл үйлчилгээ, хүнс худалдааны бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн

Ж.Мөнхбаяр – ЗДТГ-ын Жижиг дунд үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн

Т.Бямбасүрэн - Бүртгэл статистикийн газрын мэргэжилтэн

Б.Одонтунгалаг - Бүртгэл статистикийн газрын мэргэжилтэн

Б.Баатарсүрэн - Татварын хэлтсийн татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн ахлах байцаагч

Хоёр. Үйлдвэрийн улсын тооллого явуулах ажлын хэсгийг сум бүрт зохион байгуулж зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэн, төлөвлөгөөний дагуу ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг /Н.Мандсайхан/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ

Хэлтсийн мэдээллийн самбарын мэдээллийг сүүлийн 4 жилийн мэдээллээр шинэчилж байна.



Мөн аймгийн 2012-2015 оны эрэг статистик үзүүлэлтүүдээр мэдээлэл бэлтгэн гаргаж  аймгийн УИХ-ын гишүүн, Засаг дарга, ИХТ-ын дарга нар болон сумдын төрийн сангийн төлөөлөгчдөд  хүргүүлж ажиллаа.

2015 оны 4 улирал болон 2016 оны 1,2,3 дугаар улирлын статистик мэдээллээр инфографик бэлтгэн хэлтсийн вэб хуудсанд байршуулахаас гадна сар бүр статистик мэдээний хэвлэлийн хуралд ирсэн иргэдэд тарааж байлаа.

Нээлттэй хаалганы өдөрлөгийг жилд 2 удаа зохион байгуулж,Дундговь аймгийн төрийн байгууллагууд болон сургууль, цэцэрлэгүүд хамрагдлаа.

Статистикийн хэлтсийн үйл ажиллагаа болон статистик мэдээлэл, хууль эрх зүйн зориулалт, аймгийн нийгэм, эдийн засгийн гол үзүүлэлтүүдээр сүүлийн 3 жилийн байдлаар бэлтгэсэн эвхмэлүүдийг иргэд хөдөлмөрчдөдтанилцуулж, бэлтгэсэн эвхмэл материал тус бүрийг нийт 120 ширхэгийг хэвлэн тарааж, мөн сар жилээр хэвлэн гаргасан танилцуулгуудаа иргэдэд танилцуулж, иргэд хөдөлмөрчдийг мэдээллээр бүрэн хангаж, иргэдээсээ  санал асуулга авч ажиллаа.





“Монгол улсын засгийн газрын 100 хоног” нээлттэй хаалганы өдөрлөгтДундговь аймгийн төрийн байгууллагууд оролцож, тэдэнтэймэдээ мэдээлэл солилцон, статистикийн хэлтсийн үйл ажиллагаа, статистикийн мэдээлэл, хууль эрх зүйн зориулалт зэрэг эмхмэлээ дахин 50 хувь хэвлэн тараалаа,

Дундговь аймгийн Засаг даргын ажлын 100 хоног” ажлын хүрээнд төрийн бүх байгууллагууд хамрагдан тухайн байгууллага өөрийн үйл ажиллагаа болон иргэдэд хэрэгтэй мэдээ мэдээлэл өгөх өөрийн байгууллагын үйл ажиллагааг танилцуулж, өдөрлөгт амжилттай оролцлоо.

Мөн иргэдэд статистикийн байгууллагын үйл ажиллагаа, мэдээ тайлан, тооллого судалгааны ач холбогдол, зорилгын талаар мэдээлэл өгч ажилласан байна.






Дундговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн 3-р хуралдаан болж, аймаг сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга,албан газрын дарга нароролцлоо. Хурлын үеэр аймаг, сумын Засаг дарга, ИТХурлын дарга нарт Аймгийн нийгэм эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг сүүлийн 2009-2015 оны байдлаар сумчлан гаргаж, ном болгон нийт 30 ширхэгийг хэвлэн тархаалаа.






### 12. ВЭБ БАЯЖИЛТ (Ш12)

Хэлтсийн вэб хуудсыг шинэчилж хэлтсийн товч танилцуулга, хууль эрх зүй, сар бүрийн танилцуулга, аймгийн нийгэм, эдийн засгийн зарим танилцуулга, тооллого судалгааны мэдээлэл, цаг үеийн мэдээлэл, шилэн данс зэрэг мэдээллийг, сар, улирал бүр мэдээллийг шинэчлэн тогтмол оруулж хэвшээд байна.

1. Аймгийн нийгэм эдийн засгийн 1-12 р сарын танилцуулга
2. Хэвлэлийн бага хурал хийсэн персентацийг 1-12 сараар оруулсан
3. Улирал бүр инфографик хийж мэдээллийг оруулсан
4. Хөдөө аж ахуй, хүн ам өрхийн төлөв байдал, хүн амын ажил эрхлэлт, аж үйлдвэр барилгын салбарын зэрэг 4-н танилцуулгыг бэлтгэж вэб-д байршууллаа.
5. Үнийн мэдээг 7 хоног бүр шинэчилдэг




Хүн ам, өрх, хөдөө аж ахуйн динамик хүснэгт 2000 оноос 2015 он хүртэл, Мөн шинээр 95 мэдээ оруулж ажилласан байна.

Аймгийн dev-info мэдээллийн санд бүх салбарын гол үзүүлэлтүүдээр аймгийн дүн болон сумаар олон жилийн динамик бүрдүүлж вэб-д оруулаад байна.




Улирал бүр аймгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр инфографик бэлтгэж оруулсан.




Сар бүр аймгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр хэвлэлийн бага хурлын илтгэл тогтмол тавьж байна.




Хэлтсийн вэб сайтын хандалт жил бүр нэмэгдэж одоогийн байдлаар 194952 хүн хандаж мэдээ тайлан үзсэн байна.

“Devinfo МЭДЭЭЛЛИЙН САН

Энэ онд Devinfo-6.0 програмаар ҮСХ-ноос ирүүлсэн загварын дагуу нийт 19 дэд салбарын 90 үзүүлэлтийг сумчлан, 29 үзүүлэлтийг аймгийн дүнгээр шивж оруулан, мэдээллийн санг баяжуулж байна. Тэгэхдээ өрх, хүн амын тоог 1980-2015 оноор, малын тоо, хээлтэгч мал, төл бойжилт, том малын зүй бус хорогдлын дүн, төрлөөр 1942- 2015 оноор, бусад салбарын үзүүлэлтүүдийг 1992 оноос сүүлийн 22 жилээр бүрдүүлэн мэдээллийн санд шивж оруулсан. Захиргааны статистик мэдээ гаргадаг байгууллагуудад мэдээллийн санд хамрагдах үзүүлэлтүүдийг албан тоотоор хүснэгтийн хамт хүргүүлж, уг хүснэгтийн дагуу мэдээллийг гаргуулан авч мэдээллийн санг бүрдүүлж байна. Сумчилж гарч болох бүх үзүүлэлтүүдийг сумдаар оруулж, зарим аймгийн дүнгээр гардаг цөөн үзүүлэлтүүдийг аймгийн дүнгээр нь гаргасан болно.
Мөн аймгийн dev-info мэдээллийн санд байгаа салбаруудын гол үзүүлэлтүүдээр аймгийн дүн болон сумдаар олон жилийн динамикийг мэдээллийн санд байгаа онуудаар бүрдүүлж вэб-д байршуулаад байна.

## 13. МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ (Ш13)

Аймгийн нийгэм эдийн засгийн танилцуулгыг сар бүрийн 10-нд аймгийн Иргэдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга, Засаг даргын тамгын газрын дарга, Хэлтсийн дарга нарт 12 хувь хэвлэн тархаадаг ба эхний хагас жилд нийт 82 ширхэгийг тархааж бусад агентлагын дарга болон аж ахуй нэгж иргэдэд цахим байдлаар өгч байна.

2015 оны жилийн эцсийн мэдээний танилцуулгыг боловсронгуй болгон гаргаж 100 ширхэг хэвлэн тараасны зэрэгцээ сүлжээгээр өгөх, фэйсфүүк Вэб хуудсанд тавих зэргээр сурталчлах ажлыг хийсэн. Мөн “Дундговийн амьдрал” сонинд улирлын мэдээний бичмэл танилцуулгыг тогтмол хэвлүүллээ.

ҮСХ-ноос жил бүр гаргадаг Монгол улсын статистикийн эмхэтгэлийг ҮСХ-ноос 26 ширхэгийг хүлээж аваад сумдад болон Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх хэлтэс, агентлагуудад тархааж эхлээд байна.

Сар бүрийн 1-ний өдөр аймгийн Онцгой байдлын хэлтсийн Аюулаас сэргийлэх цогцолбор радио станцаар статистикийн талаарх мэдээ, мэдээллийг батлагдсан хуваарийн дагуу мэргэжилтнүүд хүргэж ажиллаж байна. Аймгийн хэмжээнд малчид болон төвийн оршин суугчид богино долгионы станцаар иргэд мэдээлэл авч байна.




Жил бүр заавал хийх ХАА-н салбарын танилцуулга, Хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтүүдийн танилцуулга, аж үйлдвэр, барилгын салбарын танилцуулга, ажил эрхлэлтийн танилцуулгыг хугацаанд нь хийж иргэдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга түүний орлогч, Засаг даргын тамгын газрын дарга, тамгын газрын харьяа хэлтэс, агентлагын дарга нарт хэвлэн тарааж танилцуулж, мөн сар бүрийн хэвлэлийн бага хуралтай хамт салбар бүрийн танилцуулгаар аймгийн хэвлэл мэдээллийн ажилтнууд болон аймгийн ЗДТГ-н хэлтсүүдийн бие төлөөлөгч нарт мэдээлэл хийж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж байна.

Дундговь аймгийн Статистикийн хэлтэс фэйсбүүк грүпп нь 691 гишүүнтэй олон нийтэд статистик мэдээллийг түгээх нэлттэй пэйж юм. Сар бүрийн танилцуулга, хэвлэлийн хурлын график мэдээлэл, салбарын танилцуулга, инфографик зэрэг мэдээллүүдийн цаг алдалгүй группэд оруулж баяжуулж ажилласан.



Манай хэлтсийн твиттер хуудас нь нийт 1039 дагагчтай мөн сар бүрийн танилцуулга, хэвлэлийн хурлын график мэдээлэл, салбарын танилцуулга, инфографик зэрэг мэдээллүүдийн цаг алдалгүй оруулж баяжуулж ажилласан.

## **<u>IV БҮЛЭГ. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ</u>**

### 14. ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ (Ш14)

- 2016 онд шинэ бүтэц зохион байгуулалттайгаар ажиллаж эхлэх болсонтой холбогдуулан дээд газрын шийдвэрийг хүлээж 4 сарын 23-ны өдөр тус хэлтсийн албан хаагчид УБСГ-ын даргатай үр дүнгийн гэрээг байгуулан ажилласан. Үйл ажиллагааны төлөвлөгөөг цаг хугацаанд нь аймгийн ИТХ-ын дарга болон Засаг даргаар нийт 32 ажил батлуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 98 хувийн биелэлттэй байна. Мэргэжилтнүүд үр дүнгийн гэрээний биелэлт, тайланг хагас бүтэн жилээр гаргаж байхаар гэрээнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Газрын хэмжээнд мөрдөж ажиллах Авилгын эсрэг төлөвлөгөөг боловсруулан албан хаагчдаар гарын үсэг зуруулж хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Авилга ашиг сонирхол, ХАСХОМэдүүлгийн талаар газрын бүх албан хаагчдад сургалт хийж бүтцийн өөрчлөлтөд орсны дагуу 4 албан хаагчаас ХАСХОМ-ийг хуулийн хугацаан гаргуулан авч программд тусгасан. Төвөөс 2009-2012 онуудын албан хаагчдын цаасаар мэдүүлсэн маягтуудыг татан авч хувийн хэрэгт байршуулсан. Аймгийн ЗДТГ-ын хуулийн хэлтэст 7 хоног тутамд гүйцэтгэсэн ажлын тайланг болон дараа 7 хоногийн ажлын төлөвлөгөөг өгч хэвшээд байна. Мөн дîëîî õîíîãáó¿ðèéí õýëòñийн цуглаанд сууж, хийсэн ажлаа дүгнэж, дараа 7 хоногт хийх ажлаа төлөвлөж хэвшсэн. Хэлтсийн албан хаагчдын хувийн хэргийн баяжилтыг хийж, ажлын байрны тодорхойлолтыг танилцуулан гарын үсэг зуруулж, ажлаас чөлөөлсөн, томилогдсон шийдвэрийн хуулбарыг хувийн хэрэгт тус бүрт хийлээ. Мөн албан хаагчдын Нийгмийн даатгалын дэвтэрт орон гарсан тушаал шийдвэрийн бичилтийг хийж баталгаажууллаа.
- Мөн өөрсдийн санаачлагаар ажилтнуудын ажиллах орчин нөхцлийг сайжруулах, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тал дээр анхааран ажиллаж, ажилчдын өрөөнд агааржуулагч тавих, цэвэр ус, цай кофегоор тасралтгүй хангах зэргээс гадна эрүүл мэндийн байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор жилд 1 удаа урьчилан сэргийлэх үзлэгт хамруулах, дасгал хөдөлгөөн тогтмол хийх үүднээс 7 хоног бүр спорт зааланд цаг авч спортын арга хэмжээ зохион байгуулах, мөн бусад байгууллагуудын дунд зохион байгуулагдаж буй тэмцээн, уралдаанд идэвхитэй оролцуулж байна. Хэлтсийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн баталгааг хангах, мэдлэг мэргэжилээ дээшлүүлэхэд байнга анхаарч ажиллаж байна. Хэлтсийн мэргэжилтэн Т.Бямбасүрэн Энэтхэг улсад тэтгэлгээр суралцах шалгалтанд тэнцэж 10 сарын хугацаатай суралцаж байна.





Мөн хэлтсийн ажилтнуудад ажлын эрч хүч, урам зориг хайрлаж, ажлын үр дүнг сайжруулах зорилгоор хамтын сан байгуулж жилд нэг удаа аялалаар авч явах, жилд 3 ажилтныг шагнаж урамшуулахаар тодорхойлон ажиллаж байна. Хэлтсийн албан хаагчдын ажлын байрны нөхцлийг сайжруулах үүднээс Хэлтсийн даргын өрөөг хувиасаа 100.0 мянган төгрөг, албанаас 450.0 мянган төгрөг гаргаж иж бүрэн засварласан бөгөөд мэргэжилтэн, судлаачдын 2 өрөөний дотор ханын заслыг өөрсдийн хүчээр хийсэн. Албан хаагчдаас 30.0 мянган төгрөгийн зардлыг гаргасан байна. Мөн ҮСХ-ноос ажилчдын албан хэрэгцээний хуучирсан хурд, хүчин чадал муутай 2 суурийн компьютрийг шинэчилж өглөө. Хэлтсийн албан хаагчдын хурлыг 7 хоног бүр хийж дотоод ажлаа ярилцан улсын хэмжээнд болон аймгаас зохион байгуулж байгаа хугацаатай ажил үүргийг маш нарийн зохион байгуулалттайгаар ажиллаж хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэхийг зорилгоо болгон ажиллаж байна. Үүний дагуу ААНБайгууллагын тооллогыг амжилттай зохион байгуулж улсад тэргүүлэн хуулийн хугацаанаас өмнө ажлыг хийж гүйцэтгэсэн. Албан хаагчдыг урамшуулах үүднээс аймгийн ЗДТГ-аас олгосон 500.0 төгрөгийн шатахуунаар БНХАУ-ын Эрээн хотод 10 хүний бүрэлдэхүүнтэй аялж ирсэн байна. Мөн хагас жилийн мал тооллого, ХАА-н өртөг, зардлын судалгаа зэрэг эхний хагас жилдээ богино хугацаагаар хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн улсын хэмжээний ажлыг төлөвлөгөөт хугацаанаас нь өмнө чанартай хийж гүйцэтгэхээр сумдын ажилчдад чиглэл хүргүүлээд ажиллаж байна.

Мөн Статистикийн хэлтсийн удирдлагуудын мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор ҮСХ-ноос үе шаттай сургалтуудыг зохион байгуулсан нь тэдний мэдлэг боловсрол, чадвар, туршлагыг сайжруулах маш сайн арга хэмжээ болж байна.

11 сард ҮСХ-нд удирдах ажилтны сургалт семинарт ахлах мэргэжилтний хамт амжилттай оролцсон.






12 сард БНСУ-ын КОСТАТ байгууллагад танилцах айлчлалд оролцож Солонгос улсын Статистикийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, явуулж буй үйл ажиллагаа, мэдээ тайлан цуглуулах, тооллого судалгаагаа зохион байгуулах арга аргачлалтай танилцаж ирсэн нь маш их зүйлийг сурч мэдсэн, туршлага болгохоор, үр дүнтэй чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.



1. Time Table

| | Time | Schedule | Speaker |
|---|---|---|---|
| 12.13 (Tue) | 10:00-10:20 | Address of welcome | |
| | 10:20-11:30 | Introduction of KOSTAT | - |
| | 11:30-13:30 | Lunch (hosted by KOSTAT) | Ms. Choi Jonghee |
| | 13:30-14:40 | Data Quality Management | - |
| | 14:40-15:00 | Coffee Break | Ms. LEE Jieun |
| | 15:00-16:20 | Managing Field Enumerations | - |
| | 16:20-17:40 | Use of Administrative Data | Mr. KIM Kwangyeol |
| 12.14 (Wed) | 09:30-10:50 | Big Data | Mr. PARK Jinho |
| | 10:50-12:00 | Open Data and its Implementation | Ms. KIM Haeryun |
| | 12:00-14:00 | Lunch | Mr. KWON Donghoon |
| | 14:00-15:20 | GIS in Statistics | - |
| | 15:20-15:40 | Coffee Break | Ms. KIM Miae |
| | 15:40-16:50 | Meta Data & KOSIS | - |
| | 16:50-18:00 | Population &Housing Census | Mr. LEE Myeongho |
| | | | Mr. LEE Jaewon |
| 12.15 (Thr) | 09:00-09:30 | STI → ETRI* * Electronics & Telecommunication Research Institute | - |
| | 09:30-11:30 | Visit ETRI | - |
| | 11:30-13:30 | Lunch | - |
| | 13:30-14:00 | Check out STI | - |
| | 14:00-16:00 | Transfer from Daejeon to Seoul | - |
| | 16:00-17:00 | Visit Government Call Center | - |
| | 17:00-18:00 | Visit Gyeong-In Regional Office | Ms.KWON Youngsim |
| | 18:00-19:30 | Dinner(hosted by Gyeong-In Regional Office) | - |
| | 19:30- | Move to Hotel and Check- In | - |
| 12.16 (Fri) | | Field Trip (Self Activities) | - |



- Хүний нөөцийн мэдээллийн сангийн баяжилтыг улирал бүр хяналт хийж, тухай бүрд мэдээллийг шинэчлэн алдаагүй бүрэн гүйцэд оруулж байна. Хүнийн нөөцийн мэдээллийн сангийн баяжилтыг хэлтсийн мэргэжилтэн Т.Бямбасүрэнгийн ажил үүргийн хуваарьт оруулан баяжилтыг тогтмол хийж байна. Тухай бүр хэлтсийн мэргэжилтэн, төрийн сан, багийн засаг дарга нар солигдох бүрт мэдээллийг шинэчлэн нэмэлт мэдээллийг баяжуулж ажиллаж байна




- Цаг үеийн шаардлагатай үйл ажиллагааны мэдээ тайланг цаг хугацаанд нь тасалдуулалгүй явуулж байна.



## 15. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ӨГӨӨЖ (Ш15)

1. Бие даасан мэдээ, тайлангийн гаргалт, түүний бодит байдал, бүртгэл, тооллого, судалгааны явц, үр дүн хийсэн хяналт шалгалтын дүнг мэдээнд хамрагдсан ААНБ, өрхөд суурилсан судалгаа, тооллогын явцын хяналт шалгалтыг дараах байдалтай хийж гүйцэтгэв.

ААНБ-ын хяналт: Статистикийн тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилт, Статистикийн мэдээллийн үндэслэл, үнэн зөв, шуурхай байдалд хяналт хийх болон НАХ-ын судалгааны ажлаар болон бусад Статистикийн ажлаар Дэрэн, Дэлгэрцогт суманд ажиллав. Эдгээр сумаас НАХ-ын судалгаанд хамрагдсан 6 ААНБ дээр очиж судалгааны талаар танилцуулж, заавар зөвөлгөө өгч өртөг зардлаа хэрхэн үнэн зөв тооцож байгаа тал дээр хяналт хийлээ. Мөн тус сумдад Хэлтсийн дарга Ж.Өлзийжаргал ажиллахдаа тус 2 суманд сар улирлын мэдээнд хамрагдаж буй 7 ААНБ-д болон 1 сүм хийдэд мэдээ тайлангийн бодит байдалд хяналт заавар зөвөлгөө өглөө.




Мөн хагас бүтэн жилийн мал тооллогын хяналтаар сумдад ажилласан тус хэлтсийн ажилтнууд сум бүрт 2 ААНБ-д хяналт хийх зорилготой ажилласан бөгөөд хагас жилийн хяналтаар нийт 8 суманд ажиллахдаа тус бүр 2 ААНБ-д буюу нийт 15 ААНБ-д мэдээ тайлангийн чанарын хяналт хийсэн. Жилийн эцсийн мал тооллогын хяналтаар мөн 8 суманд ажилласан ажилтнууд 13 ААНБ-д Статистикийн мэдээ тайлангийн чанарыг сайжруулах хяналтыг хийсэн бөгөөд нийт 36 ААНБ-д хяналт хийсэн байна.

Өрхөд суурилсан хяналт: Газрын дарга, Хэлтсийн дарга нар Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, Ажиллах хүчний судалгааны чанар байдалд дүн шинжилгээ хийх, судлаачийн ажилд үнэлгээ дүгнэлт өгөх зорилгоор аймгийн төвийн Сайнцагаан суманд ажиллаж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр судлаачдад протоколоор үүрэг өглөө.



5 дугаар сард Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан сумдад судлаач Ж.Мөнхбаярын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу хийж үнэлэлт дүгнэлт өглөө. Нийт 30 өрхийн судалгааны явцад мониторинг хийж 100 гаруй гарын авлага материалыг иргэдэд тархааж мэдээллийг өгч ажилласан байна. Мөн 10 сард судлаач Ж. Болормаагийн ӨНЭЗС, АХС хийсэн 10 гаруй өрхөд хяналт хийлээ.

Судлаачийн ажилд хяналт хийх хуваарийг хагас жил тутамд хөдөөгийн сумдад судлаач тус бүрийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх зорилгоор хийх, аймгийн төвд сар бүр хийхээр төлөвлөөд ажиллаж байна.

Ингэснээр судлаачдын гаргадаг алдаа эрс буурах, чадавхжих, иргэдэд мэдээллийг түгээх ач холбогдолтой юм.





Мал тооллогын хяналтаар ажиллахдаа тус хэлсийн мэргэжилтнүүд хяналт хийх өрхүүддээ ӨНЭЗС, АХС болон бусад тооллого судалгаанд хамрагдсан өрхүүдээс сонгон авч хяналт хийсэн бөгөөд 15 өрх нь мал тооллогоос бусад судалгаанд давхар хамрагдсан өрхүүд байсан нь өрхөд суурилсан хяналтыг нийт 55 өрхөд хийснийг харуулж байна.

Тооллого, судалгааны хяналт: Хагас бүтэн жилийн мал тооллогын хяналтыг давхардсан тоогоор нийт 18 суманд хийсэн бөгөөд эдгээр сумдад нийт 647 өрхөд мал тооллогын хяналтын баг ажиллаж, сумдын мал тооллого үнэн зөв явагдсан эсэхэд хяналт тавьж, мөн Статистикийн талаарх мэдээ, мэдээллүүдийг тархааж ажиллаад байна.





2. Бусад байгууллагатай хамтран мэдээ, тайлангийн гаргалт, түүний бодит байдал, бүртгэл, тооллого, судалгааны явц үр дүнд хийсэн хяналт, шалгалтын дүнг аймгийн Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд танилцуулж, Санхүү Төрийн сангийн хэлтэс болон Татварын хэлтэстэй хамтран Сайнцагаан сумын нийт 15 ААНБ-д, сумдад бусад ажлаар ажиллах явцдаа сумдын төрийн сангийн мэргэжилтнүүдтэй хамтран нийт 18 ААНБ-д мэдээ тайлангийн бодит байдлыг сайжруулах зорилгоор хяналт хийлээ.

Мөн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын статистикийн улсын байцаагчтай хамтран Нэгдсэн эмнэлэгт 3 удаа, Сайнцагаан сум болон Боржигонмандал, Өлзийтмандал өрхийн эмнэлгүүдэд, Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төвд, Мөнхдэлгэр, Элбэрэлбуян хувийн эмнэлэг зэрэг нийт 9 эмнэлэгт Статистик мэдээний үнэн бодит байдалд хяналт үнэлгээ хийж эмнэлгийн анхан шатны маягтын хөтлөлт болон ЭМС-ын 2013 оны 450 тоот тушаалын хэрэгжилтэнд байнга хяналт тавьж, сар бүрийн шуурхай мэдээний үнэн зөв байдлыг газар дээр нь эх материалтай тулгаж үзэн гарсан зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулж, эмч мэргэжилтнүүдэд заавар зөвлөмж өгч ажиллаж байна. Амбулатори, стационарын өвчлөл, нас баралтын base мэдээнд гарсан зөрчил дутагдлыг сумдад утсаар мэдэгдэж тухай бүр нь арилгуулж байна.

Ажилласан эмнэлгүүдийн Эрүүл мэндийн төвийн эрхлэгч нарт хугацаатай үүрэг äààëãààâàð, çàààâàð çº âëºì æ áè÷ãýýð º ã÷ àëäàà çº ð÷ëèéã àðèëãóóëñàí .

Ñòàòèñòèêèéí боловсролын улсын байцаагч нь ñóðãóóëèéí ì ýäýý BDB-1-21, цэцэрлэгийн мэдээ SUB-1-6,соёлын байгууллагын su1-17 ì ýäýýí ¿¿äèéã í ýãòãýæ сургууль, цэцэрлэг, боловсролын байгууллагуудад хяналт хийж ажиллаж байна. Энэ хичээлийн жилийн гол онцлог нь 2016-2017 оны хичээлийн жилийн сургуулийн статистик мэдээг Боловсролын мэдээллийн системийн цогц хэлбэрт шилжиж 2015-2016 оны хичээлийн жилд боловсролын удирдлагын мэдээллийн системд холбогдож сургуулийн статистик мэдээний хувьд улсын хэмжээнд давхардсан давхардал програмаар гарч тухай бүрд нь сургуулиуд хоорондоо холбогдон давхардлаа арилгаж байсан давуу талтай. Програм өргөжин ашиглаж байгаагаас зарим сургууль багшийн мэдээлэл, хүүхдийн мэдээлэл дээр хайнга хандаж цалингийн мэдээлэл, хаягийн мэдээлэл дутуу оруулсан дутагдлууд гарлаа. Мөн цэцэрлэгийн мэдээнд улсын хэмжээнд давхардал гарсныг засаж ажиллаа. Нийт 12 сургууль, 9 цэцэрлэгт хяналт хийж, мэдээний алдаа дутагдлыг засаж залруулахыг зөвлөж ажиллалаа.

Мөн Улаанбурхан, Улаанууд өвчний эсрэг дархлал тогтцын судалгааны хяналтаар ирсэн ҮСХ-ны мэргэжилтэн И.Энхбаатар, ХӨСҮТ-ийн эмч М.Энхтуяа нарын хамтаар Аймгийн ЭМГ болон Хулд, Дэлгэрхангай сумдын ЭМТөвүүдэд судалгааны явцтай болон Статистик мэдээ, тайлангийн бодит байдалтай танилцаж, мэдээ тайланг хэрхэн гаргаж байгаад хяналт тавьж хэрхэн сайжруулах талаар зөвөлгөө өгч ажиллаа.





Нийт бусад байгууллагатай хамтран хяналт хийсэн ААНБ-ын тоо 66 байна.

3. Сумдын төрийн сангийн мэргэжилтэн, багийн засаг дарга нарын сар улирлын мэдээний явц, ХАӨМС-ийн цахим сангийн шинэчлэлт хийгдэж байгаа эсэх, мөн алдаагаа засч байгаа эсэхтэй танилцаж, Улсын бүртгэл статистикийн ажилтанд статистикийн мэдээ, мэдээллийн ажлыг танилцуулж, сар улирлын мэдээнүүдийг анхан шатнаас хэрхэн цуглуулж, програмд шивж дамжуулах талаар танилцуулж ажлыг хүлээлцсэн бөгөөд Улсын бүртгэл Статистикийн ажилтнаас буцаан төрийн сангийн мэргжилтнүүдэд хүлээлгэн өгөөд байна.

Байгууллагын бүтэц, зохион байгуулалт энэ жилийн хувьд 2 удаа өөрчлөгдсөн нь сумдын анхан шатны мэдээлэл гаргадаг төрийн сангийн мэргэжилтнүүдийн ажлын чанар буурах гэх мэт сөрөгөөр нөлөөлж байлаа.

Мөн цаашид хэрхэн хамтран ажиллаж статистикийн мэдээ, мэдээллүүдийг цаг хугацаанд нь, үнэн зөв цуглуулж, дамжуулж байх талаар ярилцан зөвшилцөж, зөвөлгөө өглөө.





## 16. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА (Ш16)

Нягтлан бодох бүртгэлийн стандартыг нэвтрүүлэн, анхан шатны бүртгэлүүдийг заавар журмын дагуу хөтөлж, батлагдсан төсвийг зардлын зүйл ангид багтаан үр ашигтай захиран зарцуулж байна. Аймгийн аудитын байгууллагаар 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулалт хийлгүүлж зөрчилгүй гэсэн дүгнэлт гарсан ба цаашид мөрдөж ажиллах зөвлөмжийг  хэрэгжүүлэн ажиллаж байна. Төсвөөс олгож буй аливаа урамшуулал, унаа хоолны хөнгөлөлтөөс хүн амын орлогын албан татварын 10 хувийг суутган тооцож, татварын хэлтсийн зохих дансанд төвлөрүүлэн ажиллав.

Нягтлан бодох бүртгэлийн стандарт АСОЛОУС-програмд бүх санхүүгийн гүйлгээ, үндсэн хөрөнгө, цалингийн тооцоонуудыг оруулж хэвшсэн ба  батлагдсан төсвийг зөв зохистой, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, өр авлага үүсгэхгүйгээр, арвилан хэмнэлтийн бодлогыг тууштай нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн шилэн дансны мэдээллийн хэлтсийн вэб хуудсанд холбож хэлтсийн төлөвлөгөө, сар бүрийн мэдээ, шаардлагатай мэдээллийг тогтмол оруулж байна.

Хэлтсийн ажилтнуудад картаар эзэмшүүлж байгаа үндсэн болон эргэлтийн хөрөнгийн ашиглалт хамгаалалтанд нь байнгын хяналт тавьж ажиллаж байна.

Жилийн эцсийн санхүүгийн тайлан балансыг 1-р сарын 10-ны дотор гаргахаар бэлтгэл ажлыг хийж байна.

ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС